

**“УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР”**



# **ШИНЭ ДЭД ТӨВ**

**2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2021.01.11



## АГУУЛГА

<b>ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ</b> .....	3
Төслийг хэрэгжүүлэх үндэслэл.....	3
Төслийн товч мэдээлэл.....	4
Нийгэм, эдийн засгийн үр ашиг.....	5
Нийгмийн ач холбогдол.....	5
<b>ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ</b> .....	7
<b>Хөтөлбөрийн Нэг дүгээр үе шат – Баянхошуу, Сэлбэ Дэд Төв</b> .....	8
Товч танилцуулга.....	8
Худалдан авах ажиллагааны явц.....	10
Бүрэлдэхүүн 1. Авто зам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх.....	12
Бүрэлдэхүүн 2. Нийгэм, эдийн засгийн барилга байгууламж.....	20
Бүрэлдэхүүн 3. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын менежментийг бэхжүүлэх.....	22
Бүрэлдэхүүн 4. Төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх.....	23
Санхүүжилтын явц.....	34
<b>Хөтөлбөрийн Хоёр дугаар үе шат – Дамбадаржаа, Дэнжийн Мянга Дэд Төв</b> .....	36
Товч танилцуулга.....	36
Худалдан авах ажиллагааны явц.....	37
Бүрэлдэхүүн 1. Авто зам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх.....	39
Бүрэлдэхүүн 2. Нийгэм эдийн засгийн барилга байгууламж.....	43
Бүрэлдэхүүн 3. Төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх.....	43
Санхүүжилтын явц.....	46
<b>Хөтөлбөрийн Гурав дугаар үе шат – Толгойт, Шархад Дэд Төв</b> .....	47
Хөтөлбөрийн бэлтгэл ажлууд.....	47
<b>Хөтөлбөрийн санхүүжилтын явц</b> .....	48
<b>Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад тулгарч буй асуудлууд, сургамж</b> .....	49
<b>Хөтөлбөрийн хүрээнд дагаж мөрдөж буй бодлогын баримт бичгүүд</b> .....	51
<b>Хөтөлбөрийн үйл ажиллагааны ил тод байдал</b> .....	51



## ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

### Төслийг хэрэгжүүлэх үндэслэл

Хотын нөхцөл байдлыг сайжруулахгүйгээр өнөөгийн энэ байдлаараа байх аваас хотын ирээдүйн хүн амын тооцоолж буй өсөлт нь хотын хүрээлэн буй орчин болоод хүн амын эрүүл мэндэд ноцтой аюулыг бий болгоно. Тиймд, Улаанбаатар хотын нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгах, хотын Хойд болон баруун бүсийн хүн амд үйлчилдэг худалдаа, соёлын үйлчилгээний төвлөрөл бүхий байгаль орчинд ээлтэй ногоон орчныг бүрдүүлсэн дүүрэг бүсийн чанартай дэд төвүүдийг бий болгох замаар Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвтэй хот болгож, зохисгүй төвлөрлийг сааруулах зайлшгүй шаардлагатай болсон.

Хөтөлбөрийг Улаанбаатар хотын санаачлагаар 2008 оноос эхлэн боловсруулсан ба үүнд АХБ дэмжлэг үзүүлэн МОН-7591: МУ-ын УБ хотын цэвэр ба бохир усны үйлчилгээ ба төлөвлөлтийг сайжруулах техникийн туслалцаа, МОН-7970: УБ хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн техникийн туслалцааны төслүүдийг хэрэгжүүлсэн. Техникийн туслалцааны эдгээр төслүүдийн үр дүнд тулгуурлан Улаанбаатар хотын захиргаа хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэхэд АХБ санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр болж, Монгол Улс ба АХБ хооронд Санхүүжилтийн Ерөнхий Хэлэлцээрийг 2013 оны 12 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан. Тус СЕХ-ийн салшгүй хэсэг болох ОШСЗШ-ын удирдлагын баримт бичгийн 1 дүгээр бүлгийн 7-д тодорхойлсоноор, хөтөлбөр нь УИХ-аас 2013 оны 2 дугаар сард баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”<sup>1</sup>, “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр (2008-2016), НИТХ-ын 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 10/38 тоот тогтоолоор баталсан хөрөнгө оруулалтын хөтөлбөр зэрэг нийслэлээс гэр хорооллыг хөгжүүлэх чиглэлээр баримтлах бодлогын бусад баримт бичгүүдтэй зорилго, үйл ажиллагааны хувьд уялдаатайгаар төлөвлөгдсөн, тэдгээрийн хэрэгжилтийг дэмжихэд чиглэсэн. НИТХ-ын 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 10/38 тоот тогтоолоор хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахдаа Үе шат буюу Төсөл 1-д хамрагдах дэд төвүүдийн байршил, хөрөнгө оруулалтын хөтөлбөр ба хотын ерөнхий төлөвлөгөө хоорондын зохицуулалтыг тус тус баталсан.

ОШСЗШ-ын удирдлагын баримт бичгийн 13-т, “Хөтөлбөрийн Төсөл 1-ээр Сэлбэ ба Баянхошуу дэд төвүүдийг хөгжүүлэх Хотын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлнэ”, 14-т, “Төсөл 2-ын хүрээнд (i) Төсөл 1-д хамрагдсан Баянхошуу, Сэлбэ дэд төвүүд дэх хөрөнгө оруулалтыг гүйцээх, хотын хойд талд орших Дэнжийн 1000, Дамбадаржаа дэд төвүүдэд орон зайн шинэтгэл болон дэд бүтцийг сайжруулах;<sup>2</sup> (ii) нийгэм эдийн засгийн байгууламжийн хүртээмжийг нэмэх ажлыг дэмжих (iii) институци бүтэц болон чадавхийг бэхжүүлэх ажлыг улам боловсронгуй болгох” хэмээн төсөл тус бүрийн зорилтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон.

Түүнчлэн, Хөтөлбөрийн Төсөл 1 ба 2 нь “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”, МУ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.8, 1.2.9, 2.3.1, 2.4.22, 2.4.17 дахь заалтуудыг хэрэгжүүлэхтэй нягт уялдаа холбоотой байна. Тухайлбал, эхний шатанд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд хөгжлийн суурь болох дэд бүтцийг шинээр тавих, дэд төвийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, 2-р шатанд Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төвүүдийг хөгжүүлэх төслийн ТЭЗҮ боловсруулж, бэлтгэл ажлыг хангах зэрэг үйл ажиллагаанууд цогц байдлаар туссан.

Төслийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн баримт бичгүүдэд тодорхойлсоноор Хөтөлбөрийн үе шат 1-ийн хүрээнд хийгдэх Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд хөгжлийн суурь болох дэд бүтцийг шинээр тавих, дэд төвийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлуудыг биет болон биет бус

<sup>1</sup> АХБ-наас НЗДТГ-нд гэр хорооллын дахин хөгжүүлэлтийн стратегийг танилцуулах чиглэлд бодлогын болон зөвлөлгөө өгөх Техникийн туслалцаагаар дэмжлэг үзүүлж ирсэн (АХБ. 2010. [Монгол улсын Улаанбаатар хотын цэвэр ба бохир усны үйлчилгээ ба Төлөвлөлтийг сайжруулах Техникийн туслалцаа](#) [Манила хот [ТТ 7591-МОН]); ба Төсөл бэлтгэх техникийн туслалцаа (АХБ. 2011. [Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн Техникийн туслалцаа](#), Манила хот [ТТ 7970-МОН]).

<sup>2</sup> Санхүүжилтийн Ерөнхий хэлэлцээрт заагдсан сонголт хийх дараах шалгуур үзүүлэлтийг хангасан учраас Төсөл 2-ын зорилтот байршлуудыг сонгосон болно. Үүнд—(i) төвийн байршлын шинж буюу өргөжих, хүн ам нягтрах үйл явц эрчимтэй явагдаж байгаа; (ii) тухайн байршлууд нь нөлөөлөл/ач холбогдол ихтэй; (iii) нийгэм эдийн засгийн хувьд чухал; (iv) бохирдлын түвшин өндөртэй; (v) эдийн засгийн боломж ихтэй; (vi) Хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан байх (vii) Төсөл 1-ын Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг хамсран нэмэгдүүлэх боломж.



## Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

хөрөнгө оруулалтын ажлуудаар хэрэгжүүлж байна. Үүнд, биет хөрөнгө оруулалтын үр дүнд Хөтөлбөрийн Үе шат 1-ийн хүрээнд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд хийгдэх ба биет бус хөрөнгө оруулалтын үр дүнд тус дэд төвүүдийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх арга механизмыг тодорхойлох ба эдгээрийн үр дүнд дэд төвүүдэд бий болгосон инженерийн дэд бүтцэд түшиглэн дэд төв болон хөгжих эхлэл тавигдах юм.

### Төслийн товч мэдээлэл

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийг “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” бодлогын баримт бичигт заасан эдийн засгийн боломж, орон сууц, хотын дэд бүтцийн үйлчилгээ хангамж бүхий эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн, бие даан хөгжсөн дэд төвийн сүлжээг гэр хороололд бий болгох зорилт дэвшүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Уг хөтөлбөрийг санхүүжүүлэх 320 сая ам.долларын Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг УИХ-аар 2014 оны 05 дугаар сарын 23-ны өдөр соёрхон баталсан.

Хөтөлбөрийн зорилго нь гэр хорооллын бүсэд нийгмийн болон инженерийн дэд бүтцийг цогцоор барьж байгуулснаар Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх суурь нөхцөлийг бий болгоход оршино. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр (i) оршин суугчдад хотын суурь үйлчилгээ, нийтийн орон зай, нийгэм эдийн засгийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, (ii) эдийн засгийн хөгжлийн дэмжих, (iii) дэд бүтцийн сүлжээ өргөжсөнөөр оршин суугчид, бизнес эрхлэгчид давуу боломж олгох, (iv) барилгажих төслүүд хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Хөтөлбөрийг Азийн хөгжлийн банк (АХБ), Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ) болон Улаанбаатар хотын ЗДТГ (УБЗДТГ) хамтран санхүүжүүлэх ба нийт 3 үе шаттайгаар 6 дэд төвийн суурь дэд бүтцийн ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн үндсэн мэдээллийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага:	Нийслэлийн Засаг даргын Тамгын Газар, Төсөл хэрэгжүүлэх нэгж	
Хөтөлбөрийн хугацаа:	2014.09.24 – 2022.12.31	Сунгасан: 2014.09.24 – 2023.12.11

Эх үүсвэр	Төлөвлөсөн санхүүжилт (сая ам.доллар)	Эзлэх хувь	Шинэчлэгдсэн санхүүжилт (сая ам.доллар)	Шинэчлэгдсэн эзлэх хувь
АХБ-ны санхүүжилт	163.7	51.16%	163.7	47.56%
НЗДТГ-ын төсөв	96	30.00%	120.2	34.92%
ЕХОБ-ны санхүүжилт	60.3	18.84%	60.3	17.52%
<b>Хөтөлбөрийн нийт дүн</b>	<b>320</b>	<b>100.00%</b>	<b>344.2</b>	<b>100.00%</b>

2020 оны 4 сарын 16 нд АХБ-ны Захирлуудын зөвлөлөөр Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацааг 1 жилээр 2022 оны 12 сарын 31 нд дуусах байсныг 2023 оны 12 сарын 11 хүртэл сунгаж санхүүжилтийн дүнг шинэчилсэн

Хөтөлбөрийн хэрэгжилтийн ерөнхий явц, санхүүжилтийн эх үүсвэрийг дараах байдлаар үзүүлэв



**Санхүүжилтийн эх үүсвэр:**



**Нийгэм, эдийн засгийн үр ашиг**

- Гэр хорооллын дэд төвүүд доторх дэд бүтцийг сайжруулж дэд төвүүдийг холбосноор дэд төвүүдийг чиглэсэн хүмүүсийн болон бараа, материалын урсгал хялбар болж, хотын хөгжлийн шинэ тэнхлэг үүссэнээр бие даасан дэд төвүүд бий болно. Үндсэн гол авто зам дагасан байдлаар дэд бүтцийн шугам сүлжээг хослуулан хот төлөвлөлтийг ахисан шатанд хийснээр гэр хорооллын бүс хэв маяг, бүтцийг үндсээр нь өөрчлөх хот байгуулалтын явц зохистой болж эхэлнэ.
- Инженерийн дэд бүтцээр бүрэн хангагдсанаар дэд төвийн иргэдэд орон сууцны нөхцөлөө сайжруулах боломж бүрдэнэ.
- Иргэд газраараа хувь нийлүүлэн төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах замаар орон сууцтай болох боломж бий болно.
- Төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангасан түншлэлийн оновчтой хэлбэр бий болж газрыг зөв, дахин зохион байгуулж, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг зохицуулах зохистой механизм бүрдэнэ.
- Хууль эрх зүйн орчны шинэчлэлийг давхар хийснээр дэд төвд бизнес эрхлэх таатай боломж бүрдэнэ.

**Нийгмийн ач холбогдол**

- Хотын төвийн ачаалал буурах – тухайн дэд төвүүдэд шинээр байгуулагдах үйлдвэр, үйлчилгээний байгууллагуудад иргэд ажиллах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлуудад түр болон байнгын ажил эрхлэх боломж бий болох зэрэг таатай нөхцлийн үр дүнд хотын “зах”-аас хотын төв рүү ирэх ачаалал буурах ба олон төвтэй хот болсноор хотын төвийн төвлөрөл багасна. Хотын иргэдийн автомашинд өнгөрүүлэх цаг багасан ажлын бүтээмж, цаг ашиглалт чанаржина.
- Хотын дэд төвүүд шинээр бий болно – дэд бүтцийг бүрэн шийдсэнээр тухайн дэд төвүүдэд иргэний болон бусад төрлийн барилга байгууламж барих хувийн хэвшлийн санал санаачилга өргөжихийн хэрээр иргэдийн амьдрах тав тух хангагдсан хотын шинэ дэд төвүүд бий болно.
- Дэд бүтцийн сүлжээ өргөжнө – Дэд төвүүдийн хэсэгт явган болон авто замын бүтээн байгуулалт, цэвэр болон бохир усны дэд бүтэц хийгдсэнээр иргэд дээрх үйлчилгээнүүдийг хүртэх боломжоор хангагдана.
- Ажлын байр шинээр бий болгох – Бүтээн байгуулалтын ажлын үед иргэд олон нийт, ядуу иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-эд мэргэжлийн чиг баримжаа олгох замаар хөдөлмөр эрхлэх боломжоор хангах ба жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүрээнд



## Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудтай холбон зуучлах замаар бизнесийг дэмжсэнээр ажлын байр шинээр бий болно.


- Тав тухтай аюулгүй орчин бий болно – Гудамжны гэрэлтүүлэг бүхий явган хүний зорчих орчныг бүрдүүлсэн авто зам, олон нийтийн амралт зугаалгын талбай бүхий ногоон байгууламж бий болсноор тав тухтай орчинг бүрдүүлнэ.



### Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Хөтөлбөрийн үйл ажиллагаанууд нь харилцан хамаарал бүхий дараах үйл ажиллагаануудаас хамаарна. Үүнд:

1. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт – төслийн баримт бичигт зааснаар төслийн хүрээнд хийгдэх газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааг Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны хамгааллын бодлогыг дагаж мөрдөх үүргийг МУ-ын тал гэрээгээр хүлээсэн байна. Иймд, төслийн хүрээнд хийгдэх барилга угсралтын ажлуудын газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулан, АХБ-аар батлуулсанаар тухайн батлагдсан төлөвлөгөөний дагуу газар чөлөөлөх ажлыг хэрэгжүүлнэ.
2. Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах – газар чөлөөлөлтийн ажлыг гүйцэтгэн газрын гэрчилгээ гарснаар барилгын тухай хууль болон холбогдох дүрэм журмын дагуу тухайн баригдах объектод техникийн нөхцлүүдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудаас авч зураг төслийг эцэслэн боловсруулна. Зураг төслийн ажил дууссанаар төслийн худалдан авах ажиллагааг эхлүүлэх боломж бүрддэг.
3. Төслийн худалдан авах ажиллагаа – төслийн баримт бичигт зааснаар төслийн хүрээнд хийгдэх бараа материал, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг АХБ-ны худалдан авах ажиллагааны журмын дагуу АХБ-аас баталсан төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу АХБ-ны зохих хяналттайгаар зохион байгуулна.
4. Төслийн үйл ажиллагаа – төслийн хүрээнд хийгдэх барилга угсралтын аливаа бүх ажлууд нь төслийн худалдан авах ажиллагаа, газар чөлөөлөлт бүрэн дууссанаар хэрэгжиж эхлэх бөгөөд барилгын ажлын явцад хяналт тавьж үр шим хүртэгчид хүлээлгэн өгнө.



### ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ

Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрт заасны дагуу АХБ-ны худалдан авах ажиллагааны журам, Хамгааллын бодлогын баримт бичиг болон АХБ-ны холбогдох журмуудыг баримтлан ажилдаг.

Төслийн өртөг:	<p><b>Үе шат-1 АХБ-наас</b> 22.50 сая ам.доллартай тэнцэх зээлжих тусгай эрх бүхий зээл, 27.5 сая ам.долларын ердийн эх үүсвэрийн хөнгөлөлттэй зээл, 3.7 сая ам.долларын буцалтгүй тусламж. <b>ЕХОБ-наас</b> 22.01 сая долларын зээл. <b>Монгол улсын Засгийн газраас</b> 33.15 сая ам доллар. Нийт <b>108.86</b> сая ам доллар.</p>	<p><b>Үе шат-2 АХБ-наас</b> 29.24 сая ам.долларын зээлжих тусгай эрх бүхий зээл, 37.11 сая ам.долларын ердийн эх үүсвэрийн хөнгөлөлттэй зээл. <b>ЕХОБ-наас</b> 19.64 сая еврогийн зээл. <b>Монгол улсын Засгийн газраас</b> 35.15 сая ам доллар. Нийт <b>121.14</b> сая ам доллар.</p>
Төслийн хугацаа:	I Үе шат: 2014.09.24 – 2021.06.30	II Үе шат: 2017.03.14 – 2022.02.28

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлыг тэргүүлэгчдийн 2014 оны 107 тоот тогтоолоор Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг анх баталсан бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/586 тоот захирамжаар Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, Төслийн удирдах хорооны даргаар Нийслэлийн Засаг дарга ажиллаж байна

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 108 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг Даргын 2014 оны А/551 тоот захирамжаар “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр –ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулж, бүтэц орон тоог шинэчлэн баталж /11 ажилтан/ баталсан.

Монгол улсын сангийн сайдын 2019 оны 72 тоот тушаалаар “Тэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц орон тоог шинэчлэн нийт 25 ажилтантай баталсан .

Төслийн удирдлагын нэгж нь Төслийн зохицуулагч, дэд зохицуулагч 2, хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн, худалдан авах ажиллагааны мэргэжилтэн, санхүүгийн мэргэжилтэн 1,



## Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

гэрээний мэргэжилтэн, нүүлгэн шилжүүлэлтийн мэргэжилтэн 2, байгаль орчны мэргэжилтэн, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн, ерөнхий инженер, барилгын инженер 2, замын инженер 2, усан хангамж, ариутгах татуургын шугамын инженер 2, цахилгааны инженер, дулааны инженер, хот зохион байгуулалт төлөвлөлтийн мэргэжилтэн, оффис менежер, жолооч 2, МТ-ийн мэргэжилтэн гэсэн нийт 25 хүний орон тоотой төслийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн жинлэсэн явц нь 38,15% байгаа бөгөөд энэ нь 2020 онд 8.44%-ын өсөлттэй байсан байна. Дараах хүснэгтээс үе шат бүрээр хэрэгжилтийг харна уу

Хөтөлбөрийн санхүүжилт			Хувиарласан жин	Бодит явц	Жинлэсэн явц
		<b>ГУН байгуулах</b>	<b>2.00%</b>	<b>100.00%</b>	<b>2.00%</b>
1 үе шат	108,860,000.00	ГЧНШ	5.43%	100.00%	5.43%
		Худалдан авалтын үйл ажиллагаа	5.43%	99.22%	5.37%
		Барилгын ажил	18.60%	82.18%	15.29%
		Зөвлөх үйлчилгээ	1.55%	96.94%	1.50%
		<b>Нийт</b>	<b>31.00%</b>	<b>89.02%</b>	<b>27.60%</b>
2 үе шат	121,140,000.00	ГЧНШ	5.95%	50.42%	3.00%
		Худалдан авалтын үйл ажиллагаа	5.95%	38.56%	2.29%
		Барилгын ажил	20.40%	13.36%	2.73%
		Зөвлөх үйлчилгээ	1.70%	24.22%	0.41%
		<b>Нийт</b>	<b>34.00%</b>	<b>24.75%</b>	<b>8.43%</b>
3 үе шат	114,200,000.00	ГЧНШ	5.60%	0.00%	0.00%
		Худалдан авалтын үйл ажиллагаа	5.60%	2.12%	0.12%
		Барилгын ажил	19.20%	0.00%	0.00%
		Зөвлөх үйлчилгээ	1.60%	0.00%	0.00%
		<b>Нийт</b>	<b>32.00%</b>	<b>1.56%</b>	<b>0.12%</b>
		<b>Төслийн хаалт</b>	<b>1.00%</b>	<b>0.00%</b>	<b>0.00%</b>
<b>Нийт</b>	<b>344,200,000.00</b>		<b>100.00%</b>		<b>38.15%</b>

Хөтөлбөрийн нийт төлөвлөсөн хэрэгжүүлэх хугацааны 70.20% нь өнгөрөөд байгаа бөгөөд төслийн хэрэгжилтийн явц удаашралтай байна.

## ХӨТӨЛБӨРИЙН НЭГ ДҮГЭЭР ҮЕ ШАТ – БАЯНХОШУУ, СЭЛБЭ ДЭД ТӨВ

### ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Баянхошуу дэд төвд хамаарах Сонгинохайрхан дүүргийн 7,8,9,10,11,28,40 дүгээр хороонд нийт 162 га газар, Сэлбэ дэд төвд хамаарах Сүхбаатар дүүргийн 13,14 дүгээр хороо, Чингэлтэй дүүргийн 14,18 дугаар хорооны 156 га газар нутаг байна.

Хөтөлбөрийн 1 үе шатыг дараах зорилтуудад хүрэхийн төлөө хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

- Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийг инженерийн дэд бүтцээр бүрэн хангаж, хотын дэд төв болон хөгжих суурь нөхцөлийг бүрдүүлнэ.
- Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, дэд төвийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх арга механизмыг тодорхойлон хэрэгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн дагуу талуудын харилцан тохиролцсон Олон шатлалт санхүүжилтийн зээлийн удирдлагын баримт бичиг (ОШСЗУББ)-т тодорхойлсны дагуу Төсөл 1-ийн нийт санхүүжилт 104.5 сая ам.доллар ба үүний 53.7 сая ам.доллар буюу 51.38%-ийг АХБ, 28.38 сая ам.доллар буюу 27.15%-ийг ЕХОБ, үлдсэн 22.42 сая ам.доллар буюу 21.45%-ийг Нийслэлийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөгдсөн. Төслийн дунд хугацааны хяналт үнэлгээг АХБ-аас 2017 оны 02 дугаар сард хийсэн ба энэ үеэр төслийн зардлын тооцооллыг шинэчилсэн. Шинэчилсэн



Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

тооцооллоор Төсөл 1-ийн нийт санхүүжилт 108.86 сая ам. доллар ба үүний 53.7 сая ам.доллар буюу 49.33%-ийг АХБ, 22,01 сая ам. доллар буюу 20.22%-ийг ЕХОБ, үлдсэн 33.15 сая ам. доллар буюу 30.45%-ийг НЗДТГ хариуцана. Төслийн зардлын таамаглалыг дор дэлгэрэнгүй үзүүлэв.

**Төслийн хөрөнгө оруулалтын шинэчилсэн төлөвлөгөө**

(сая ам.доллар)

Эх үүсвэр	Санхүүжилт		Эзлэх хувь
	Анхны төлөвлөсөн	Шинэчлэгдсэн	
АХБ-ны санхүүжилт			
МОН-3099 (COL)	22.5	22.5	20.67
МОН-3098 (OCR)	27.5	27.5	25.26
МОН-0380 (COL)	3.7	3.7	3.4
<b>Дэд дүн</b>	<b>53.7</b>	<b>53.7</b>	<b>49.33</b>
НЗДТГ-ын төсөв	22.44	33.15	30.45
ЕХОБ-ны санхүүжилт FG'83097	28.38	22.01	20.22
<b>Нийт</b>	<b>104.52</b>	<b>108.86</b>	<b>100</b>

(сая ам.доллар)

№	Үндсэн үйл ажиллагаа	Эхний таамаглал	Шинэчлэгдсэн	Өсөлт /Бууралт	
				Мөнгөн дүнгээр	Хувиар
<b>А. Суурь зардал</b>		<b>93.13</b>	<b>97.47</b>	<b>4.34</b>	<b>4.66%</b>
<b>I</b>	<b>Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх</b>	<b>80.43</b>	<b>84.77</b>	<b>4.34</b>	<b>5.40%</b>
1.1	Автозам сайжруулах	24.59	28.93	4.34	17.65%
1.2	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, үйлчилгээг сайжруулах	25.70	25.70	0.00	0.00%
1.3	Дулааны шугам сүлжээ, үйлчилгээг сайжруулах	30.14	30.14	0.00	0.00%
<b>II</b>	<b>Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үр ашгийг нэмэгдүүлэх</b>	<b>3.70</b>	<b>3.70</b>	<b>0.00</b>	<b>0.00%</b>
<b>III</b>	<b>Эдийн засгийн болон нийгмийн байгууламжийг нэмэгдүүлэх</b>	<b>5.00</b>	<b>5.00</b>	<b>0.00</b>	<b>0.00%</b>
<b>IV</b>	<b>Байгууллагыг чадавхижуулах</b>	<b>4.00</b>	<b>4.00</b>	<b>0.00</b>	<b>0.00%</b>
4.1	Хөтөлбөрийн менежментийн дэмжлэг	2.00	2.00	0.00	0.00%
4.2	Үйлчилгээ үзүүлэгчдийг дэмжих	0.50	0.50	0.00	0.00%
4.3	Дэд төвийн хөгжил ба иргэдийн оролцоог хангах	1.50	1.50	0.00	0.00%
<b>Б. Магадлашгүй ажил</b>		<b>7.39</b>	<b>7.39</b>	<b>0.00</b>	<b>0.00%</b>
<b>В. Хэрэгжүүлэх үеийн санхүүгийн хураамж</b>		<b>4.00</b>	<b>4.00</b>	<b>0.00</b>	<b>0.00%</b>
<b>Нийт дүн</b>		<b>104.52</b>	<b>108.86</b>	<b>4.34</b>	<b>4.15%</b>

Төслийн зардал нэмэгдэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл нь төслийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн зардал анх таамаглаж байсан 1.02 сая ам.доллараас 10.49 сая ам.доллар болж өссөн



## Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

үзүүлэлт болно. Төслийн хүрээнд хийгдэх дэд бүтцийн болон нийгмийн байгууламжуудын байршлыг холбогдох байгууллагуудтай зөвшилцөн тодорхойлоноор төслийн хүрээнд газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтэнд өртөх нэгж талбарын тоо хэмжээ тодорхой болсон ба үүнд хамаарах нөхөн олговрын зардлыг илүү бодитой таамаглах нөхцөл бүрдсэнтэй холбоотой.

Хөтөлбөрийн 1-р үе шатыг дараах бүрэлдэхүүн хэсгүүдээр хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх
2. Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд
3. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын менежментийг бэхжүүлэх
4. Төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх

Хөтөлбөрийн 1-р үе шатны хүрээнд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийг бүтээн байгуулалтын ажлыг 2021 онд дуусгахаар төлөвлөсөн бөгөөд 1-үе шатны хэрэгжилтийн явц 89.02% байна.

Үйл ажиллагаа	Хуваарилсан жин	Бодит явц	Жинлэсэн явц
<b>ГЧНШ</b>	<b>17.50%</b>	<b>100%</b>	<b>17.50%</b>
<b>ХАА</b>	<b>17.50%</b>	<b>99.12%</b>	<b>17.36%</b>
Барилгын ажил	15.00%	99.77%	14.97%
Зөвлөх үйлчилгээ	2.00%	100.00%	2.00%
Бараа	0.50%	77.92%	0.40%
<b>Барилга угсралт</b>	<b>60.00%</b>	<b>82.18%</b>	<b>49.31%</b>
Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх	34.22%	79.00%	27.04%
Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд	5.64%	91.98%	5.18%
Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын менежментийг бэхжүүлэх	2.50%	100.00%	2.50%
Усны барилга байгууламжууд	17.64%	82.70%	14.59%
<b>Зөвлөх үйлчилгээ</b>	<b>5.00%</b>	<b>96.94%</b>	<b>4.85%</b>
<b>Нийт</b>	<b>100.00%</b>		<b>89.02%</b>

Хөтөлбөрийн 1-р үе шатны хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийн тоймыг дараах хүснэгтээс харна уу

Барилга байгууламж	Баянхошуу дэд төв	Сэлбэ дэд төв
<b>Автозам</b>	6.5 км төлөвлөснөөс 4.9 км хийгдсэн	6.6 км төлөвлөснөөс 5.4 км хийгдсэн
<b>Цахилгааны шугам сүлжээ</b>	4 км төлөвлөснөөс 4 км хийгдсэн	1.9 км төлөвлөснөөс 1.9 км хийгдсэн
<b>Дулаан хангамжийн шугам сүлжээ</b>	14 км төлөвлөснөөс 12.8 км хийгдсэн	8.7 км төлөвлөснөөс 8.4 км хийгдсэн
<b>Ус хангамжийн шугам сүлжээ</b>	10.9 км төлөвлөснөөс 9.3 км хийгдсэн	4 км төлөвлөснөөс 3.8 км хийгдсэн
<b>Ариутгах татуургын шугам сүлжээ</b>	16.6 км төлөвлөснөөс 15.8 км хийгдсэн	9.3 км төлөвлөснөөс 8.3 км хийгдсэн
<b>Үерийн хамгаалалтын далан суваг</b>	2.4 км төлөвлөснөөс 2.4 км хийгдсэн	2.1 км төлөвлөснөөс 2.1 км хийгдсэн
<b>Талбайн тохижилт</b>	3.01 га талбайн ажил – 85.9%	4.65 га талбайн ажил – 88.3%
<b>Усан сан</b>	1000м <sup>3</sup> - 92.75%	1000м <sup>3</sup> - 100%
<b>Гүүр</b>	-	3ш – 100%
<b>Дулааны станц</b>	-	26 МВт – 78.03%
<b>Мэдээлэл холбооны үйлчилгээний төв</b>	1ш – 82%	1ш – 100%
<b>Бизнес инкубатор, сургалтын төв</b>	1ш – 100%	1ш – 100%




<b>Хүүхдийн цэцэрлэг</b>	240 хүүхдийн, 1ш – 100%	240 хүүхдийн, 1ш – 100%
--------------------------	-------------------------	-------------------------

Барилгын ажлын дэлгэрэнгүй мэдээллийг барилгын ажлын явц хэсгээс харна уу

### ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ

Хөтөлбөрийн 1 үе шатанд нийт 4 төрлийн эх үүсвэрээс 48 багц худалдан авалт (29 барилгын ажил, 5 бараа материал ханган нийлүүлэх, 14 зөвлөх үйлчилгээний) зохион байгуулахаар төлөвлөснийг бүрэн гүйцэтгэж гэрээг байгуулсан бөгөөд АХБ-ны хүсэлтийн дагуу дараах 3 барилгын ажил, 4 бараа материал нийлүүлэлтийн худалдан авалтыг нэмэлтээр хийхээр тохиролцсон.



№	Ажлын нэр	Худалдан авалтын явц
1	Баянхошуу дэд төвд НОСК-ын чөлөөлсөн талбайд түр хашаа барих (TFBA)	Мандах оройн товгор ХХК-тай 2020 оны 12 сарын 25-нд гэрээ байгуулсан
2	Баянхошуу дэд төвд НОСК-ын чөлөөлсөн талбайг цэвэрлэх (SCBA)	Эхний зарласан тендер цуцлагдсан. Тендерийн дахин зарлах ТББ-ыг бэлтгэж байна.
3	Сэлбэ дэд төвийн дулааны станцын туршилт тохируулгын ажил (SHPTC)	ТББ-ыг бэлтгэж байна
4	Сэлбэ дулааны станцид ачааны машин механизм (SHPM)	ТББ-ыг бэлтгэж байна
5	Сэлбэ дулааны станцын офисын тавилга (SHPOF)	ТББ-ыг бэлтгэж байна
6	Сэлбэ дулааны станцид машин (SHPOV)	ТББ-ыг бэлтгэж байна
7	Сэлбэ дулааны станцын галын хоолой болон тоног төхөөрөмж (SHPSW)	ТББ-ыг бэлтгэж байна


Тайлант хугацааны явцад дээрх 6 ажлын худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулж байгуулж байгаа бөгөөд төслийн худалдан авалтын үйл ажиллагааны хэрэгжилт 99,12% тай байна.

Гэрээ байгуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт 1-т** үзүүлэв**БҮРЭЛДЭХҮҮН 1. АВТО ЗАМ БОЛОН ХОТЫН ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ**

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн зорилт нь дэд төвүүдэд авто зам болон хотын дэд бүтцийн суурь үйлчилгээ (ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамж)-г өргөжүүлэн, тэдгээрийн хоорондын холболтыг сайжруулснаар хотын орон зайн хэв шинжийн өөрчлөлтийг эхлүүлэх бөгөөд энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд АХБ болон ЕХОБ-ны санхүүжилтээр хийгдэх 23 ажлын гэрээг байгуулан барилгын ажлын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаа. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн барилгын ажлын явцыг дараах хүснэгтээр үзүүлж байна.

№	Багцын дугаар	Ажлын нэр	Гүйцэтгэгч	Ажлын явц
<b>АХБ-ны санхүүжилт</b>				
1	BHF06	Дулааны шугамын өргөтгөл шинэчлэл	ЧММ ХХК, Эс&ай трейд ХХК түншлэл	100.0%
2	BRDH11	Баянхошуу Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - Үе шат 1	Янчен Шинго констракшн ХХК	74.72%
3	BRDH14	Баянхошуу Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - Үе шат 2	Людвиг пфайфер, Пфайфер лейпзиг түншлэл	75.37%
4	BEC13	Баянхошуу Цахилгаан, холбооны шугам сүлжээ	Одкон холдинг ХХК, Одкон эрчим ХХК түншлэл	88.98%
5	SBR08	Сэлбэ дэд төвийн Гүүр	ЗМЗ ХХК	97.60%
6	SHF06	Сэлбэ Дулааны станц, 26МВт, 1ш	Хүрд ХК, Шиншанг гоншен бойлер ХХК түншлэл	78.03%
7	SRDH11	Сэлбэ Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - Үе шат 1	Вайт феоникс ХХК, Хасу мегават ХХК, Эвттрак ХХК түншлэл	86.54%
8	SRDH14	Сэлбэ Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - үе шат 2	Набсан ХХК, Тэргүүн инвест ХХК, Тэргш плант ХХК түншлэл	71.11%
9	SEC13	Сэлбэ Цахилгаан, холбооны шугам сүлжээ	Дорнын их гэгээ ХХК, Монхас ХХК түншлэл	92.00%
<b>ЕХОБ-ны санхүүжилт</b>				
10	BCM1	Баянхошууны 1-р хэсгийн өөрийн урсгалтай ариутгах татуургын баилгын ажил	Бумбод ХХК, ДҮКБ ХХК түншлэл	100.0%
11	BCM2	Баянхошууны 2-р хэсгийн өөрийн урсгалтай ариутгах татуургын шугамын барилгын ажил	Бумбод ХХК, ДҮКБ ХХК түншлэл	100.0%
12	SCM	Сэлбэ Бохирын гол шугам	Хүрд ХК, Зэст хөлөг ХХК түншлэл	100.0%
13	BSDF07 Lot 1	Үерийн хамгаалал, далан суваг	Хангилцаг ХХК	100.0%
14	WSNR17C	Орос 14-өөс төвийн шугам	Модерн ХХК, Монгол менежмент төв ХХК түншлэл	100.0%
15	WWTPR01	Төв цэвэрлэх шинэчлэл	Си&эй трейд ХХК, Набсан ХХК түншлэл	100.0%
16	BSWR10 Lot 2	Усан сан	Санжат ХХК	100.0%
17	BSDF07 Lot 2	Үерийн хамгаалал, далан суваг	Экспресс зам ХХК	100.0%
18	BSPE	Яндан хоолой нийлүүлэх	ЧММ ХХК	100.0%

19	WSC16A	Салбар шугамын холболт	Одкон холдинг ХХК, Улаанбаатар барилга ХХК түншлэл	86.75%
20	BSWR10 Lot 1	Баянхошуу Усан сан	Бумбод ХХК, Одкон холдинг ХХК түншлэл	92.75%
21	BSDF07B	Баянхошуу Үерийн хамгаалалын суваг, шинэ	Монгол менежмент төв ХХК, Байгууламж ХХК түншлэл	75.80%
22	WSNR17A	Улаанбаатар хотын зүүн хойд бүсийн усан сангаас Тасганы усан сан хүртэлх	Грийн ресурс ХХК	32.66%
23	WSNR17B	Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх 7054м	Монинжбар ХК, НАБ ХХК	57.83%



**Сэлбэ дэд төвд 28 Мвт дулааны станцын барилгын зураг төсөл, ханган нийлүүлэлт, барилга угсралтын ажил**

Хүчин чадал / үзүүлэлт:	28МВт хүчин чадалтай дулааны станц - 3ш зуух; Оффисын барилга – 2 давхар; Ус бэлтгэлийн барилга; Нүүрсний агуулахын барилга;
Гүйцэтгэгч:	"Хүрд" ХК, "Шиншиан Гонгшен бойлер" ХХК-ийн түншлэл
Гэрээний дугаар:	SHF06 - Ажлын явц: 78.03%



**Баянхошуу дэд төвд баригдах цахилгаан, холбооны шугам сүлжээ, барилга угсралтын ажил**

<i>Хүчин чадал / үзүүлэлт:</i>	2*16/35/10МВА-ын цахилгааны дэд станц - 1ш; 10кВ-ийн хуваарилах байгууламж - 1ш; 2*630/10/0.4кВА-ын хаалттай дэд өртөө - 2ш; Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төв - 1ш; 35кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам - 4000м; 10 кВ кабелийн шугам - 2300м; Холбооны худаг, сувагчлал, шилэн кабель - 2948м;
<i>Гүйцэтгэгч:</i>	“Одкон Холдинг” ХХК, “Одкон Эрчим” ХХК-ийн түншлэл
<i>Гэрээний дугаар:</i>	ВЕС13 - Ажлын явц: 88.98%

**35/10кВ-ийн дэд станц**



**35/10кВ-ийн дэд станц**

**Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төв**



**35/10кВ-ийн дэд станцын тоноглол**



**Хаалттай дэд өртөөний барилга**



**10кВ-ийн хуваарилах байгууламжийн барилга**



**Сэлбэ дэд төвд баригдах цахилгаан, холбооны шугам сүлжээ, барилга угсралтын ажил**

Хүчин чадал / үзүүлэлт:	35кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам - 1935м; 2*16/35/10МВА-ын цахилгааны дэд станц - 1ш; 10 кВ кабелийн шугам - 549м; 2*630/10/0.4кВА хаалттай дэд өртөө - 2ш; Холбооны худаг, сувагчлал, шилэн кабель - 2768м; Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төв - 1ш;
Гүйцэтгэгч:	“Дорнын Их Гэгээ” ХХК, “Монхас” ХХК-ийн түншлэл
Гэрээний дугаар:	SEC13 - Ажлын явц: 92.00%

**Хаалттай дэд өртөөний барилга 1**



**Мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилга**



**35/10кВ-ийн дэд станц**



**35/10кВ-ийн дэд станцын дотор тоноглол**



**Хаалттай дэд өртөөний барилга 2**



**Сэлбэ дэд төвд авто зам, дулааны шугам сүлжээ болон бусад дэд бүтцийн шугам сүлжээний ажил**

Хүчин чадал / үзүүлэлт:	Цэвэр усны шугам - 3970м; Бохир усны шугам - 9270м; Авто зам - 6598м; Дулааны шугам 8697м; Ус дулаан дамжуулах төв - 6ш;
Гүйцэтгэгч:	White Phoenix LLC, Nasu Megawatt LLC, Evtruck LLC түншлэл, Набсан ХХК, Тэгш Плант ХХК, Тэргүүн Инвест ХХК түншлэл
Гэрээний дугаар:	<b>SRDH11 – 86.54%, SRDH14 – 71.11%</b>




<b>Хүчин чадал / үзүүлэлт:</b>	Цэвэр усны шугам - 2170м; Бохир усны шугам - 4566.8м; Авто зам - 3653м; Дулааны шугам - 3450м; Ус түгээх байр - 1ш; Ус дулаан дамжуулах төв - 6ш;
<b>Гүйцэтгэгч:</b>	ХБНГУ-ын “Людвиг Пфайфер Кассел”, “Людвиг Пфайфер Лайпциг” ХХК-иудын түншлэл, Yangchen Co.,Ltd
<b>Гэрээний дугаар:</b>	BRDH14 - Ажлын явц: 75.37%



**Баянхошуу дэд төвийн усан хангамж, ариутгах татуурга, халуун ус болон дулааны шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, бараа тоног төхөөрөмж нийлүүлэх болон суурилуулах ажил**

<p><b>Хүчин чадал / үзүүлэлт:</b></p>	<p>Хилчин хотхоныг төвлөрсөн дулаанд холбох - 1.0 км; /100%/                  227-р цэцэрлэг, СХД-ийн 7-р хорооны барилгыг төвлөрсөн дулаанд холбох - 0.32 км;                  СХД-ийн Эрүүл мэндийн 3-р амбулатори, Дүүргийн цагдаагийн 2-р хэлтэс, 163, 78-р цэцэрлэгүүд, 76-р сургууль, сургуулийн өргөтгөл, 9-р хорооны барилгыг төвлөрсөн дулаанд холбох нийт 0.8 км, болон бохир усны шугамд холбох - 1.0 км;                  67-р сургууль, 117-р цэцэрлэгийг төвлөрсөн дулааны шугамд холбох - 0.6 км, болон бохир усны шугамд холбох - 0.4 км;                  Баянхошуу дэд төвийн Түр суурьшуулах орон сууцны барилгыг төвлөрсөн дулаанд холбох - 0.4 км, болон бохир усны шугамд холбох - 0.4 км;</p>
<p><b>Гүйцэтгэгч:</b></p>	<p>“Одкон Холдинг” ХХК, “Улаанбаатар Барилга” ХХК-ийн түншлэл</p>
<p><b>Гэрээний дугаар:</b></p>	<p>WSC16A - Ажлын явц: <b>85.75%</b></p>



2-т үзүүлэв.

ажлын улсын комисст хүлээлгэн өгснийг хавсралт

Дээрх хүүлэгэн өгсөн барилгуудын ажлаас дараах үр дүн гарч байна.



1. Баянхошууны 1, 2-р хэсгийн өөрийн урсгалтай ариутгах татуургын барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр СХД-ийн 4.5.7.8.9.10.11.18.26 хорооны хэрэглэгчдийн айл өрх албан байгууллагын бохир усыг татан зайлуулж цаашдаа хөрсний бохирдол багасах, эрүүл ахуйн нөхцөл сайжрах, усны зохистой хэрэглээ бий болох, байгаль орчинд эерэг сайн нөлөө үзүүлэх нөхцөл байдлууд үүсэж эхлэнэ.
2. Сэлбэ дэд төвийн бохирын шугам сүлжээний барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр Сэлбэ дэд төвийн Чингэлтэй талын хэрэглэгчдийн айл өрх албан байгууллагын бохир усыг татан зайлуулж цаашдаа хөрсний бохирдол багасах, эрүүл ахуйн нөхцөл сайжрах, усны зохистой хэрэглээ бий болох, байгаль орчинд эерэг сайн нөлөө үзүүлэх нөхцөл байдлууд үүсэж эхлэнэ.
3. Баянхошуу дэд төвд нийт 2,3 км үерийн хамгаалалтын сувгийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэснээр үерийн улмаас гудамж талбайд ус тогтох болон оршин суугчид усанд автахаас сэргийлсэн байна.
4. Улаанбаатар хотын Орос 14-р сургууль орчмын барилга байгууламжийн бохирын татуургын гол цуглуулах шугамын барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр одоо ашиглагдаж байгаа шугам сүлжээний хүчин чадал нь барилгажих явцад хүрэлцэхгүй болсон байсныг өргөтгөн шинэ барилгуудыг шугам сүлжээнд холбох боломжтой болоод байна.
5. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилга болон аэротанкийн бетон хийцийн шинэчлэлтийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дараах үр дүн гараад байна. Үүнд:
  - Тоног төхөөрөмж, барилга байгууламжийн насжилтыг 20-25 жил уртасгасан.
  - Цэвэрлэгээний төвшин 2-10 хувь дээшилсэн.
  - Байгаль орчинд учруулах бохирдолтын хэмжээг багасгасан.
6. Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны 1и магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дараах үр дүн гараад байна. Үүнд:

Ханын материал, Баянхошуу орчмын барилга байгууламж, хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох нөхцөл бүрдэж, шинээр дулааны магистраль шугам Баянхошуу дэд төв рүү татах боломж үүссэн.


7. Сэлбэ дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус хангамжийн шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дэд төвүүдийг найдвартай усны эх үүсвэртэй холбож өгч байна
8. Сэлбэ дэд төвд нийт 2,4 км үерийн хамгаалалтын сувгийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэснээр үерийн улмаас гудамж талбайд ус тогтох болон оршин суугчид усанд автахаас сэргийлсэн байна.



## БҮРЭЛДЭХҮҮН 2. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн зорилт нь хүн амын эрэлтийг хангахуйц, хотын функц ба ач холбогдлыг өндөржүүлэхүйц, ажлын байр бий болгохуйц хөрөнгө оруулалтыг нийгэм, эдийн засгийн байгууламжид хийснээр төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бөгөөд энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 12 ажлын гэрээ байгуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаа. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн барилгын ажлын явцыг дараах хүснэгтээр үзүүлж байна.

№	Багцын дугаар	Ажлын нэр	Гүйцэтгэгч	Ажлын явц
1	BSF05 Lot 1	240 хүүхдийн цэцэрлэгийн барилга	Ус орчин ХХК	100.0%
2	BSF05 Lot 2	МСҮТ, бизнес инкубаторын барилга	Томо билдинг ХХК, Би эм си эм ХХК түншлэл	100.0%
3	SSF05 Lot 1	240 хүүхдийн цэцэрлэгийн барилга	Цаст констракшн ХХК	100.0%
4	SSF05 Lot 2	МСҮТ, бизнес инкубаторын барилга	Бридж констракшн ХХК, Монхас ХХК	100.0%
5	BFKA	Баянхошуу цэцэрлэгийн тавилга, тоног төхөөрөмж	Декора ХХК, Чиглэл ХХК	100.0%
6	BEF	Баянхошуу бизнес инкубаторын тавилга, тоног төхөөрөмж	Ай ти зон ХХК, Декора ХХК, Профешнл сивил инженеринг констракшн ХХК	100.0%
7	SFKA	Сэлбэ цэцэрлэгийн тавилга, тоног төхөөрөмж	Профешнл сивил инженеринг констракшн ХХК, Чиглэл ХХК	100.0%
8	SEF	Сэлбэ бизнес инкубаторын тавилга, тоног төхөөрөмж	Улстуяарах ХХК, Декора ХХК	100.0%
9	BSLS09 Lot 1	Баянхошуу Тохижилт, ландшафт, 4.65 га	Дүүрэн трейд ХХК, Байгууламж ХХК түншлэл	88.30%
10	PP01-SW	Баянхошуу дэд төвд Орлогод нийцсэн орон сууцны туршилт, 20 айлын орон сууц, 1ш	Томо билдинг ХХК, Саруул сайхан ХХК түншлэл	35.63%
11	TFBA	Чөлөөлсөн талбайг хашаалах НОСК, 1500м	Мандах оройн товгор ХХК	0.00%
12	BSLS09 Lot 2	Сэлбэ Тохижилт, ландшафт, 3.01га	Боди протертиз ХХК	85.90%



**Баянхошуу дэд төвийн тохижилтын ажил**

Хүчин чадал / үзүүлэлт:	Үерийн далангийн дагуу хийгдэх гадна тохижилт, ногоон байгууламж- 4.65 га;
Гүйцэтгэгч:	“Дүүрэн Трейд” ХХК, “Байгууламж” ХХК-ийн түншлэл
Гэрээний дугаар:	<b>BSLS09, Багц 1 - Ажлын явц: 88.3%</b>



Нийт 4 ажлын барилгын ажлыг бүрэн хэрэгжүүлэн 4 багц худалдан авалтын тоног төхөөрөмжийн хамт улсын комисст хүлээлгэн өгснийг **Хавсралт 3-т** үзүүлэв.

Дээрх хүлээлгэн өгсөн барилгуудын ажлаас дараах үр дүн гарч байна.

1. **Баянхошуу дэд төвд барих 240 хүүхдийн цэцэрлэгийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дараах үр дүн гараад байна. Үүнд:**



Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

2018 оны 12-р сард ашиглалтанд орж, үйл ажиллагаагаа эхлүүллээ. Ингэснээр, тус дэд төвийн цэцэрлэгт хамрагдаж чаддаггүй байсан 331 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж, нийт 41 багш ажилчид ажлын байртай боллоо.

**2. Баянхошуу дэд төвд барих МСҮТ, бизнес инкубатор төвийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дараах үр дүн гараад байна. Үүнд:**

2020 онын 3 сард Баянхошуу Бизнес Инкубатор төв нээлтээ хийж, иргэдэд үйлчилж эхэлсэн бөгөөд 2020 оны 12-р сарын эцсийн байдлаар Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, Баянхошуу салбар, нийт 198 төрлийн төрийн үйлчилгээ, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний төвийн салбар, Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газар, инкубатор өрөөнд бойжигчид, Төсөл хэрэгжүүлэх нэгж, Иргэдийн мэдээллийн төв, Азийн Сангийн Бизнес Эрхлэгч эмэгтэйчүүдийн төв, бизнес эрхлэгч эмэгтэйчүүд, Дэлхийн Зөн, Төгсөлтийн аргачлал-600, зорилтот өрхийн бүлэг, Дэд төвийн хороодын бизнес эрхлэгч иргэд(үсчин, үндэсний гутал хийдэг гэр бүл) гэх мэт байгууллага, иргэд үйл ажиллагаагаа явуулж, нийт 37 хүн байнгын ажлын байртай боллоо.

**3. Сэлбэ дэд төвд барих 240 хүүхдийн цэцэрлэгийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дараах үр дүн гараад байна. Үүнд:**

2020 оны 9-р сард ашиглалтанд орж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд тус дэд төвийн цэцэрлэгт хамрагдаж чаддаггүй байсан 265 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж, нийт 38 багш ажилчид ажлын байртай боллоо.

**4. Сэлбэ дэд төвд барих МСҮТ, бизнес инкубатор төвийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дараах үр дүн гараад байна. Үүнд:**

2020 оны 9 сард нээлтээ хийж, одоогоор Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төвийн 9 ажилтан ажиллаж байна.

### **БҮРЭЛДЭХҮҮН 3. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙГ БЭХЖҮҮЛЭХ**

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн зорилт нь ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн үйлчилгээг сайжруулснаар үйлчилгээний байгууллагуудын үр ашгийг дээшлүүлэх бөгөөд АХБ-ны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр УСУГ-ын үйл ажиллагааг сайжруулах 3,370 сая ам долларын гэрээг Комфорт импекс ХХК, Хунан шаню ХХК-ын түнлэлтэй байгуулан гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж ашиглагч байгуулагад хүлээлгэн өгсөн.

Уг буцалтгүй тусламжийн дэд төсөл хэрэгжсэнээр УСУГ-т нэгдсэн удирдлагын СКАДА систем байгуулж, үүнд шаардагдах тоног төхөөрөмжүүдийг шинэчлэн сайжруулснаар усны алдагдлыг илрүүлэх зэргээр үйл ажиллагааны горимыг сайжруулж, ус, эрчим хүчний хэмнэлт үүсгэн ашиглалтын зардлыг бууруулахаар төлөвлөгдсөн бөгөөд энэ төслийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Үйлдвэр, Мах, Төв болон гаурт насос станцуудын тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн
- Үйлдвэрийн насос станцад 1 өргөгчийн насос станцын гүний худгийн 16 ширхэг насосыг иж бүрнээр нь шинэчлэн суурилуулсан
- Төвийн насос станцын эх үүсвэрийн 2 өргөгчийн 4 насос, 6 кВ-ын давтамж хувиргагчийг барилгын хамт барьж ашиглалтанд оруулсан
- Түгээх сүлжээний хяналтын 30 болон хэмжих 40 худгуудын барилга угсралтыг гүйцэтгэсэн
- УСУГ-ын удирдлагын төвд СКАДА систем, усны алдагдал илрүүлэх систем суулгасан
- Нэгдсэн удирдлагын программ хангамжыг суурьлуулан ашиглалтад оруулсан.
- Нийт 39,7 мянган м урт шилэн кабель суурьлуулсан
- Төвийн эх үүсвэрийн 6кВ-ын 750кВт-ын хүчин чадал бүхий цахилгаан хөдөлгүүрт давтамж хувиргагч суурьлуулснаар 3 насос хөдөлгүүрийг удирдан ажиллах бүрэн боломжтой болсон

Үүний үр дүнд өмнөх 3 жилийн дунджаар 1м3 ус усыг 0,64кВт/цаг жрчим хүчээр олборлон түгээдэг байсан бол 2018 онд 0,51кВт/цаг болж 0,12 кВт/цагийн эрчим хүчний хэмнэлттэй ажиллаж эхэлсэн байна. Гэрээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг Хавсралт 4-т үзүүлэв.



#### **БҮРЭЛДЭХҮҮН 4. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ**

Энэ бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь хот төлөвлөлт, дэд төвүүдийн хөгжлийг боловсронгуй болгох, дэд төвийн бүтээн байгуулалтын талаарх иргэдийн ойлголтыг төлөвшүүлэх, тэдний оролцоог хангах, дэд бүтцийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, менежментийг сайжруулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхийг дээшлүүлэх замаар институцыг бэхжүүлж, чадавхижуулахад оршино.

##### **ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ**

Төсөл нь худалдан авалт, газар чөлөөлөлт, барилга угсралт гэсэн үндсэн 3 чиглэлийн үйл ажиллагаагаар дамжин хэрэгжих бөгөөд төслийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх 5 төрлийн зөвлөх үйлчилгээтэй байхаар төлөвлөгдсөний дагуу хэрэгжиж байна. Хөтөлбөрийн зорилго, зорилтод хүрэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор (i) Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах; (ii) Төслийн удирдлагын дэмжлэг үзүүлэх; (iii) Хот төлөвлөлт ба дэд төвийн хөгжлийг сайжруулах; (iv) Олон нийтийн оролцоо болон жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил; (v) Хотын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах гэсэн 5 зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан эхний 4 зөвлөх үйлчилгээний хэрэгжилтийг хангуулан ажилласан бөгөөд Хотын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах зөвлөх үйлчилгээний Завсрын тайланд санал хүргүүлэн эцэслэхээр хүлээгдэж байна.

##### **Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах**

Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг Дохва инженеринг ХХК, Корэа дүүргийн дулааны корпораци түншлэлтэй байгуулан хөтөлбөрийн 1 үе шатны инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлын хяналт, хөтөлбөрийн 2-р үе шатны ТЭЗҮ боловсруулах ажлууд багтсан.

###### **i. Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах**

Зураг төсөл боловсруулалтын ажлын явц удаашралтай гүйцэтгэдсэн бөгөөд инженерийн нарийвчилсан зураг төслийг урьдчилсан байдлаар буюу экспертзийн ерөнхий дүгнэлтгүйгээр 2017 оны 3 сарын 31-нд 6 удаа гэрээний хугацааг сунгасны эцэст хүлээн авсан.

Нарийвчилсан зураг төслийг экспертээр батлуулахад газрын гэрчилгээтэй холбоотой асуудал үүссэн ба ТУН-ын дэмжлэггүйгээр нэгдсэн дүгнэлт гаргуулах асуудлыг шийдвэрлэн 2017 оны 12 сарын 05-нд эцсийн байдлаар нарийвчилсан зураг төслүүдийг хүлээлгэн өгсөн.

БХБЯ болон НЕТГ-ын өгсөн заавар зөвлөмжийн дагуу хөтөлбөрийн 1-р үе шатны анхны төлөвлөгөө өөрчлөгдсөнтэй холбоотойгоор төслийн инженерийн байгууламжийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажилд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Баянхошуу дэд төвийн дулааны шугам сүлжээний ажил хасагдсан
- Баянхошуу болон Сэлбэ дэд төвийн цахилгаан, холбооны шугам сүлжээний ажлууд хасагдсан
- Дулааны шугам сүлжээний өргөтгөлийн ажил нэмж хийх
- Цахилгаан, холбооны шугам сүлжээ, шинээр тавих дулааны шугам сүлжээний ажлуудыг түлхүүр гардуулах нөхцөлөөр хийх

Төслийн хүрээнд хийгдэх нийт 24 багц ажлаас 11 ажлын зураг төслийг зөвлөх баг боловсруулах, 1 ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр буюу зураг төсөл боловсруулахгүйгээр шууд худалдан авалт хийх, үлдсэн 10 ажлын зураг төсөл боловсруулах ажил болгон өөрчилсөн.

Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт тусгагдаагүй 1 байгц ажлын 5 нь НЗДТГ-ын захиалгаар зураг төсөл хийгдсэн УСУГ-ын ус хангамж, ариутгах татуургын го шугамын шинэчлэлийн өргөтгөлийн ажлууд, 3 нь төслийн хүрээнд бие даасан зөвлөх ажиллуулж боловсруулсан, 4 нь түлхүүр гардуулах нөхцөлтэй хийгдэх гэрээ байна.

АХБ-тай зөвшилцсөний үндсэн дээр дулааны шугам сүлжээний өргөтгөлийн ажлын зураг төсөл боловсруулах ажлыг ашиглагч байгууллагын хүсэлт, үндэслэлд тулгуурлан шууд худалдан авалт хийн Гандирс-Од ХХК-аар хийлгэхээр гэрээ байгуулсан.

Хөтөлбөрийн 1-үе шатны хүрээнд хийгдэх зарим ажлын зураг төслийн НХОГ-аас боловсруулсан байсан бөгөөд шинээр нэмэгдсэн ажлуудын зураг төслүүдийг боловсруулах ажлуудыг зөвлөх



Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

үйлчилгээгээр Гандирс од ХХК, Ричвелл инженеринг ХХК, Усны эрчим ХХК, УХАТ ХХК, Арктэйп Монгоия ХХК, Престиж инженеринг ХХК зэрэг компаниудаар боловсруулсан.

ii. Барилгын ажлын хяналт

Зөвлөхийн гэрээний инженерийн зураг төсөл боловсруулалтын ажлын гүйцэтгэл, гүйцэтгэлийн чанар болон хяналт тавих арга арга зүй, аргачлал зэргийг харгалзан үзэж барилгын ажлын хяналт хийхийг шийдэхээр зөвлөх багтай тохирсон боловч дээрх бүх үйл ажиллагаа чанарын шаардлага хангахгүй хугацаны хоцрогдол их байсан тул зөвлөх үйлчилгээний гэрээг 2018 оны 07 сарын 2-ны өдөр 63,3%-ийн хэрэгжилттэйгээр дуусгавар болгосон.

Зөвлөх багын гэрээ дуусгавар болсонтой холбоотойгоор ТХН-ын МУ-ын Барилгын тухай хууль болон журмын шаардлагуудыг ханган ажиллах зорилгоор Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраар барилгын ажлын явцад захиалагчийн хяналт тавиулах саналыг АХБ-нд хүргүүлэн батлуулж захиалагчийн хяналтын гэрээг НХОГ-тнй 2018 оны 5 сард байгуулсан.

АХБ-ны Худалдан авах ажиллагааны журам болон бусад дотоодын журмуудад нийцүүлэн ашиг сонирхлын зөрчилгүй байх нөхцөлийг бүрдүүлэн зохиогчийн хяналтыг хийх ажлыг олон улсад нээлттэй зарлан зөвлөх сонго шалгаруулж 2019 оны 06 сарын 19-нд гэрээ байгуулсан.

Нэмэлтээр хийгдсэн ажлуудын зохиогчийн хяналтыг зөвлөх үйлчилгээгээр зураг төслийг боловсруулсан байгууллагуудаар хийлгүүлэн ажиллаж байна.

2020 оны байдлаар захиалагчийн болон зохиогчийн хяналтын ажлуудыг барилгын ажлын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэн ажиллаж байна.

iii. Хөтөлбөрийн 2-р үе шатны ТЭЗҮ боловсруулах

ТЭЗҮ боловсруулах зөвлөх баг хөтөлбөрийн 2-р үе шатны ТЭЗҮ эцсийн тайланг 2017 оны 02 сард ТХН-д хүлээлгэн өгсөн.

**Хот төлөвлөлтийг сайжруулах, дэд төвийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах**

Хот төлөвлөлтийн сайжруулах Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг 2015 оны 9-р сард байгуулсан. Энэхүү зөвлөх үйлчилгээгээр иргэдийн оролцоотой дэд төвийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, дэд төвийг лахин хөгжүүлэх арга замыг тодорхойлох, хот төлөвлөлт болон газар дахин зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр чадавх бэхжүүлэх гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

i. Иргэдийн оролцоотой дэд төвийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хөгжлийг арга замыг тодорхойлох

Улаанбаатар хотыг хөгжүүлэх бодлогын баримт бичгүүд болон нэгж хорооллын ерөнхий төлөвлөгөө зэрэг холбогдох баримт бичгүүдийг судлан холбогдох байгууллагууд болон дэд төвийн иргэдтэй зөвлөлдөх уулзалт хийн Баянхошуу болон Сэлбэ дэд төвүүдийн хөгжлийн төлөвлөгөөг хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, дэд төвийг блокоор хөгжүүлэх концепци, арга зүй, аргачлал, дэд төвийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төлөвлөгөө зэрэг өргөн хүрээг хамруулан боловсруулж 2017 оны 8 сард анхны хувилбарыг танилцуулсан.

Анхны хувилбарт АХБ-ны хоболгдох мэргэжилтнүүдийг саналыг тусган нийслэлийн холбогдох байгууллагад танилцуулан хэлэлцүүлж эцсийн байдлаар 2018 оны 6 сарын 30-нд хүлээлгэн өгсөн.

Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагын дагуу НЗДТГ-аас мэргэшсэн мэргэжилтэн зайлшгүй шаардлагатай байгаа хэрэгцээг тодорхойлж СЯ-нд санал гарган ТХН-д энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх орон тоог Сангийн сайдын тушаалаар шинэчлэн батлуулсан.

Тайлангын хугацаанд ТХН-ээс энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор дараах ажлуудыг гүйцэтгээд байна. Үүнд:

- Хот төлөвлөлт болон газар дахин зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр чадавх бэхжүүлэх

Нийт 15 дэд бүлгийн 74 асуулт бүхийн өөрийгөө үнэлэх судалгаанд Нийслэлийн хот төлөвлөлт ерөнхий төлөвлөгөөний газар, НОСК, НЗДТГ-ын Стратеги бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийслэлийн газрын алба, БХБЯ-н ЭХЯ-ны Стратеги бодлого төлөвлөлтийн газар зэрэг газруудын



Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

мэргэжилтнүүдийг хамруулан сургалтын хэрэгцээг тодорхойлсон бөгөөд сургалтын хөтөлбөр, агуулгыг тодорхойлж чадавх бэхжүүлэх хөтөлбөр боловсруулав.

Холбогдох байгууллагын удирдлагуудад судалгааны дүн сургалтын хөтөлбөрийг танилцуулан 3 долоо хоногийн 44 цагын сургалтыг зохион байгуулсан.

### Төслийн удирдлагын дэмжлэг үзүүлэх

Төслийн удирдлагын дэмжлэг үзүүлэх үйлчилгээний гэрээг 2015 оны 6 сарын 05-нд Франц улсын Эжис интернайншл ХХК-тай байгуулсан. Зөвлөх үйлчилгээ нь хөтөлбөрийн 1-р үе шатны хугацаанд төсөл хэрэгжүүлэх нэгжид АХБ-ны дүрэм журам зааврын дагуу төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чадавх бэхжүүлэх зорилготой.

- Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг чадахжуулах

Төслийн нэгжийн ажилчдын сургалтыг ажлын байрны сургалт болон албан сургалт гэсэн хоёр хэлбэрээр зохион байгуулсан

Албан сургалтын хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, MS Project программ, АЗ сертификат олгох сургалт, АХБ-ны Худалдан авах ажиллагааны журам, АХБ-ны Хамгааллын бодлого ба түүнийг хэрэгжүүлэх, Нийгмийн хамгаалал, байгаль орчин ба аюулгүй байдал, Газар чөлөөлөлт ба нүүлгэн шилжүүлэлт, албан бичиг хэрэг хөтлөлт ба цагийн менежмент, багийн ажиллагаа, байгууллагын ёс зүй, харилцааны ур чадвар, асуудлыг шийдвэрлэх чадвар зэрэг сэдвүүдээр сургалтуудыг зохион байгуулсан.

Ажлын байран дахь сургалтыг барилга угсралтын ажлын гэрээний удирдлага, түлхүүр гардуулах гэрээний удирдлага сэдвээр олон улсын зөвлөхийн удирдлага дор зохион байгуулж гэрээний хэрэгжилтэд хяналт тавих холбогдох ажилтнуудыг хамруулсан. Мөн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн асуудлаар НЗДТГ-ын холбогдох албаны хүмүүс, мэргэжилтнүүдийг хамруулсан, семинар зохион байгуулсан

- Хөтөлбөрийн санхүүгийн менежментийн тогтолцоог бий болгон, цахим бүртгэлийн систем бүрэн нэвтрүүлэх

Санхүү бүртгэл, тайлагналын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зах зээлд өргөн хэрэглэгдэж буй туршигдсан программ хангамжийг худалдан авч хэрэгцээнд нэвтрүүлсэн. Уг программын тусламжтайгаар ТХН-ийн санхүүгийн тайлангуудыг илүү үр ашигтай болгож, холбогдох байгууллагуудын шаардлагад нийцүүлэн цаг алдалгүй, хугацаанд нь тайлагнах боломж бүрдсэн юм. АХБ-ны санхүүгийн менежментийн бодлого журмын талаар ажлын байранд дагалдан сургах ажлыг хийсэн ба тухайн он тус бүрээр санхүүгийн төсөөллийг гаргаж төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлсэн.

- Худалдан авах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

Төслийн худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэнд тендерийн үнэлгээний тайланг холбогдох журам болон тендерийн баримт бичигт заасан шаардлагуудын дагуу үнэлсэн эсэхийг нягталж шалгах, тендерийн үнэлгээний тайланд өгсөн сануулга, тодруулгын дагуу холбогдох тайлбарыг нотлох баримтуудын хамт бэлтгэн хүргүүлэх, тендерийн үнэлгээний тайланг эцэслэх зэрэгт мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажилласан. Мөн төслийн хэрэгжүүлэх нэгжийн бэлтгэсэн тендерийн баримт бичгийг хянан тохиолдуулах АХБ-наас ирүүлсэн заавар зөвлөмжийн дагуу засаж сайжруулах, холбогдох дүрэм журмын дагуу тайлбар хийх зэрэгт дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагуудаар хянуулж батлуулахтай холбоотойгоор төслийн байгаль орчны Нарийвчилсан үнэлгээний тайланг шинэчлэх ажлыг гүйцэтгэх зөвлөх сонгон шалгаруулахад дэмжлэг үзүүлэн, зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулсан

Байгаль орчны хөндлөнгийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн, зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулсан.

- АХБ-ны хамгааллын бодлогын дагуу холбогдох бичиг баримтуудыг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх

2017 онд байгуулсан нийт 12 барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан гүйцэтгэгчдийн боловсруулсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянахад мэргэжлийн туслалцаа үзүүлсэн.



Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

- Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө, нийгмийн болон жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих

Хамгааллын бодлогын дагуу Төслийн нийгмийн үйл ажиллагааны болон жендерийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, нөлөөлөлд өртөж буй иргэдийг ганцаарчилсан ярилцлага хийх замаар мэдээлэл цуглуулах, оршин суугчдын зөвлөлтэй хамтран эдгээр зөвлөлийн биелэлтийг төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, уулзалтууд зохион байгуулах зэргээр төслийн хэрэгжүүлэх нэгж болон дэд төвийн оршин суугчидтай нягт хамтран ажиллав

Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулах, АХБ-аар батлуулах, шаардлагатай тохиолдолд газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэргээр төслийг хэрэгжүүлэх нэгжтэй, хамтран ажилласан.

Зөвлөх баг үүргийн дагуу гэрээтэй ажлуудыг гүйцэтгэн эцсийн тайлангаа 2018 оны 12 сард хүлээлгэн өгсөн.

Иргэд олон нийтийн оролцоог хангах болон ЖДҮ-г хөгжүүлэх

Хөтөлбөрийн I үе шатны Баянхошуу, Сэлбэ дэд төвийн иргэд, олон нийтийн оролцоог хангах, жижиг дунд үйлдвэрийг дэмжих үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээг НҮБ-ын Хабитат олон улсын байгууллагатай 2015 оны 7 сард байгуулан 2018 оны 12 сарын 31 хүртэл хамтран ажилласан.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд иргэдийн оролцоог хангах зорилгоор анхан шатны оршин суугчдаас бүрдсэн анхдагч бүлэг, анхдагч бүлгийн ахлагч, нарийн бичгээс бүрдсэн дэд төвийн оршин суугчдын зөвлөлийг байгуулж оршин суугчдын хошуучлалтай “Ард түмний үйл ажиллагаа” олон улсын аргачлалыг нэвтрүүлэн иргэдэд төслийн талаарх мэдээлийг тогтмол хүргэж, төслийн хэрэгжилтэд иргэдийн оролцоог хангуулан ажлуулсан. Энэхүү олон улсын аргачлалын хүрээнд Сэлбэ дэд төвд 717 гишүүнтэй 70 анхдагч бүлэг, 129 гишүүнтэй 3 оршин суугчдын зөвлөл, 18 гишүүнтэй 1 дэд төвийн оршин суугчдын зөвлөлийг зохион байгуулсан. Эдгээр оршин суугчдын анхдагч бүлгүүдийг дэмжин зохион байгуулалтад оруулснаар эдгээрийг нэгтгэсэн анхдагч бүлгүүдийн төлөөлөл бүхий Баянхошуу дэд төвд 1, Сэлбэ дэд төвд 2 /Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар дүүрэг/ оршин суугчдын зөвлөл болох ТББ-ууд бий болж дэд төвийн хөгжлийн явцад хуулийн этгээдээр оролцох боломжтой болсон.

Оршин суугчдын зөвлөлийн үйл ажиллагаа идэвхжиж байгааг илтгэх нэг үзүүлэлт нь гишүүдийн тоо бөгөөд энэхүү өсөлтийг 2015-2019 онуудад хэрхэн өссөн байдлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

Оршин суугчдын байгууллага		2015	2016	2017	2018/2019
Баянхошуу дэд төв	Анхдагч бүлгийн тоо	9	27	29	90
	Анхдагч бүлгийн гишүүд	274	448	466	989
	ОСЗ-ийн тоо	6	6	6	6
	Гишүүд	36	72	76	162
Сэлбэ дэд төв	Анхдагч бүлгийн тоо	14	29	31	70
	Анхдагч бүлгийн гишүүд	172	371	443	717
	ОСЗ-ийн тоо	2	2	2	3
	Гишүүд	28	58	62	129

Нийслэл, дүүрэг, хороодын удирдлагууд, албан хаагчид, дэд төвийн иргэд, оршин суугчдад 249 уулзалт болон үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 6647 хүнд Баянхошуу, Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалтын явцын танилцуулга хийж иргэдийн дуу хоолойг сонсож тухай бүрд нь бүтээн байгуулалтын ажилд иргэдийн санал бодол орон нутгийн хэрэгцээг тусгаж хамтран ажилласан.

ТХН болон зөвлөх багын мэргэжилтнүүд, орон нутгийн иргэд, оршин суугчдын зөвлөлийг чадваржуулах 26 сургалтыг үе шаттайгаар 920 хүнд иргэдийн оролцооны байгууллага, харилцаа холбоо тогтоох, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, хамтын ажиллагааны түншлэл, хяналт, үнэлгээ, төлөвлөгөө, оршин суугчдын зөвлөл, түүний удирдлага, менежмент, бичиг баримт боловсруулах гэх мэт сэдвүүдээр зохион байгуулж оролцогчдыг чадавхжууллаа.

Дэд төвүүдийн иргэл оршин суугчдад төслийн хэрэгжилтийн талаарх хэлэцүүлэг уулзалтуудыг тогтмол зохион байгуулж мэдээлээр ханган ажилласан.



## АХБ-НЫ ХАМГААЛЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

### Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц

Төслийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг Санхүүжилтийн хэлэлцээрийг үндэслэн АХБ-ны Хамгааллын бодлого, журмын дагуу зохион байгуулахаар Монгол Улсын Засгийн газар үүрэг хүлээсэн ба үүнд холбогдох зардлыг Нийслэлийн төсвөөс бүрэн хариуцахаар зээлийн хэлэлцээрт туссан бөгөөд Нийслэлийн газар зохион байгуулалтын алба газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн чиглэлээр дараах 80 орчим бичиг баримтуудыг боловсруулж АХБ болон НЗД-аар батлуулахад оролцон, хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

- Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн хамрах хүрээ,
- Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө – 8
- Нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд өртсөн иргэдийн нийгэм, эдийн засгийн судалгаа – 60 гаруй боть
- Нөлөөлөлд өртсөн иргэдийн газар хөрөнгийн үнэлгээ – 8
- Нүүлгэн шилжүүлэлтийн хөндлөнгийн үнэлгээний тайлан

Байршил	Ажлын нэр	Нөлөөлөлд өртсөн өрхийн тоо			
		нийт	хагас	бүтэн	газрын эрхгүй
Баянхошуу дэд төв	Зам, инженерийн шугам сүлжээ	445	209	130	106
	Цэцэрлэг, МСҮТ, Цахилгааны 35/10кВ дэд өртөө	27	0	27	0
	Усан сан	13	1	12	0
	Төвлөрсөн дулаанд холбох 3,2 км шугам	43	32	11	0
	Төвлөрсөн дулаанд холбох	8	4	4	0
	Үерийн далан	20	16	4	0
	Бохир усны коллекторын ажил	77	77	0	
Сэлбэ дэд төв	Зам, инженерийн шугам сүлжээ	479	147	187	145
	Дулааны станц	27	0	26	1
	Цэцэрлэг, МСҮТ	19	0	19	0
	Бохир усны коллекторын ажил	17	17	0	0
Дэд төвөөс бусад байршил	КТМС-талх чихэр хүртэлх цэвэр болон бохир усны 11 км шугам	11	7	3	1
<b>Нийт</b>		<b>1238</b>	<b>544</b>	<b>434</b>	<b>260</b>

Хөтөлбөрийн 1 дүгээр үе шатанд Баянхошуу Сэлбэ төвийн байршилд хэсэгчлэн 544, бүтнээр 434 нэгж талбарын газрыг чөлөөлж нийт 1238 өрх нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд өртсөн байна. Нөлөөлөлд өртөж буй нэгж талбарын эзэдтэй 100% зөвшилцөж, нөхөн олговрын захирамж батлагдаж, нийт 1219 айл нөхөн олговрын мөнгөө бүрэн хүлээн авч, газраа чөлөөлсөн бол 11 айл өрх нөхөх олговороо авахаар гэрээ байгуулан хүлээгдэж байна.

Нийслэлийн төсвөөс нөхөн олговорт нийт 39,6 тэрбум төгрөг, дэмжлэгт 256 сая төгрөгийг зарцуулаад байна. Хэсэгчлэн өртсөн нийт 313 нэгж талбарын кадастрын зургыг шинэчлэн хийлгэж, Нийслэлийн газар зохион байгуулалтын Газар чөлөөлөх хэлтсээр дамжуулан газрын мэдээллий нэгдсэн санд 170 орчим нэгж талбарын өөрчлөлтийг хийлгэж 90 орчим айлын газрын гэрчилгээг холбогдох дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээр баталгаажуулан, гаргуулж иргэдэд олгосон. Мөн нөлөөлөлд өртсөн айл өрхийн хашаанд хамт амьдарч байсан газрын эрхгүй 253 өрхөд газар олгох ажлыг Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгоно хайрхан гэсэн дүүргүүдийн 37 байршилд 200-290 м<sup>2</sup> газар, Хан-уул дүүргийн 12-р хороо Морингийн даваанд 250м<sup>2</sup> газар, НОСК-ийн түрээсдлээд өмчлөх орон сууцны хөтөлбөрт хамруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тайлант хугацаанд ГЧНШ-ын ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн бөгөөд нэмэлтээр хийгдэх ажлуудтай холбогдуулан нэмэлтээр газар чөлөөлөх ажлууд нэмэгдсэн байна. Үүнд:

- Баянхошуу дэд төвийн нэмэлт ажил /орц гарцны асуудалтай айл өрх/
- Сэлбэ дэд төвийн нэмэлт ажил /орц гарцны асуудалтай айл өрх/



## Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

- Нөлөөлөлд өртсөн газрын эрхгүй иргэдэд 37 болон Морин даваанд газар эзэмшүүлэх, түрээслээд өмчлөх байранд хамруулах

Газар чөлөөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажил дараах шалтгаанудын улмаас тодорхой хугацаанд хоцорсон. Үүнд

- Зөвшилцсон иргэдийн нөхөн олговор олгох НЗД-ын захирамж гаргах, нөхөн олговор шилжүүлэх явц олн үе шаттай хугацаа алддаг
- Иргэд газраа чөлөөлөх боломжгүйгээс зургийн өөрчлөлт хийгдэж шинээр айлуудтай нэмж зөвшилцөх шаардлага бий болсон.

### Кадастрын зураг, газрын гэрчилгээний өөрчлөлт

Дэд төвүүдийн бүтээн байгуулалтын ажлын трасст хагас өртөж газраа чөлөөлсөн нийт 314 (үүнээс Баянхошуу дэд төвд 198, Сэлбэ дэд төвд 116) нэгж талбарын кадастрын зургийн өөрчлөлтийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлэн хагас өртсөн айлуудын кадастрын өөрчлөлтийг нийслэлийн газрын мэдээллийн санд оруулж нийт 307 нэгж талбарт, шинээр 299 нэгж талбарын кадастрын зураглал, гэрчилгээг гаргуулж иргэдэд олгоод байна.

### Нөлөөлөлд өртсөн газар эзэмших, өмчлөх эрхгүй иргэдэд газар олгох

АХБ-ны Нийгмийн хамгааллын бодлогын дагуу боловсруулан батлуулсан Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнд заасны дагуу төслийн нөлөөлөлд өртөж, нүүх шаардлагатай болсон өөрийн гэсэн газрын эрхгүй өрх тус бүрд одоогийн амьдарч буй газраас нь дордуулахгүй нөхцөлтэй газар олгох шаардлагатай гэж заасан байдаг. Энэ заалтыг биелүүлээгүй улмаас АХБ-наас төслийн хэрэгжилтийг 2 сар гаруй хугацаанд зогсоосон

Төслийн хүрээнд нөлөөлд өртсөн нийт 978 нэгж талбарын 412 нь газраа бүрэн чөлөөлж байгаа бөгөөд 48% нь хашаандаа хоёроос дээш өрхтэй амьдарч байсан. Иймээс урьдчилсан байдлаар газрын эрхгүй амьдарч байгаад нүүсэн болон нүүх шаардлагатай болсон 253 өрх байна

Дээрх 253 газрын эрхгүй өрхүүдэд суурь дэд бүтцээр хангагдсан нийтийн үйлчилгээтэй газар олгох эсвэл зорилтот бүлгийн орон сууц санал болгох зэрэг боломжит хувилбаруудыг санал болгон баталгаажуулж, тухайн иргэдтэй зөвшилцөн сонгосон хувилбаруудыг Нийслэлийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар 03 дугаар сарын 12-ны өдөр хэлэлцүүлж, хурлын шийдвэрийн дагуу боломжит газруудын эзэмшлийг өөрчилөн Нийслэлийн Засаг даргын А/421, А/422 тоот захирамжуудыг батлуулсан. Газрын эрхгүй нийт 253 иргэнээс нийслэлийн дүүргүүд доторх 37 байршилд 84, Хан-Уул дүүргийн 10 дугаар хороон дахь Морингийн даваанд 103, СХД-ийн 6 дугаар хороонд баригдах Ханын материалын түрээслээд өмчлөх байранд 34 иргэн авахаар бүртгүүлсэн ба ямар нэгэн сонголт хийхгүй гэсэн 6 иргэн, газар сонголтлоо хийгээгүй 26 иргэн байна. Үүнээс Нийслэлийн Засаг Даргын А/675 тоот захирамж нь 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдөр батлагдаж, 144 газрын эрхгүй иргэнд нийслэлийн гурван дүүргийн 37 байршилд болон Морингийн даваанд газар олгоогоод байна.

Нийслэлийн Засаг даргын А/675 дугаар захирамжийн дагуу иргэдийн гэрчилгээ кадастрын зургийг нэн яаралтай гаргаж өгөх тухай 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 952 тоот албан бичгийг Нийслэлийн Газар Зохион Байгуулалтын албанд хүргүүлсэн ба 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 180 иргэний гэрчилгээ, кадастрын зураг Нийслэлийн Газар Зохион Байгуулалтын албанаас ирүүлээд байна.

Төсөл хэрэгжүүлэх нэгжээс Морин Давааны гэр хорооллын баруун талд нийт 110 өрхөд эзэмшүүлэх газрын байршлын эргэлтийн цэг тэмдэгтийг тэмдэгжүүлэн улаан шугам татаж иргэд зааж өгөх ажлыг 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдөр байр зүйн зураглалын тусгай зөвшөөрөл бүхий “Голден Лайн” ХХК-иар гүйцэтгүүлэн ажилласан.

Дэд төв	Морин даваанд газар сонгосон	37 байршилд газар сонгосон	Газар сонгохгүй гэсэн	Түрээслээд өмчлөх байр сонгосон	Газар сонгоогүй	Нийт
Баянхошуу	44	25	2	13	14	98
Сэлбэ	66	55	4	21	9	155
<b>НИЙТ</b>	<b>110</b>	<b>80</b>	<b>6</b>	<b>34</b>	<b>23</b>	<b>253</b>



## Нөлөөлөлд өртсөн иргэдэд нөхөн олговрын зөрүүг олгох

2020 оны 05 дугаар сарын 18-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт зохион байгуулсан хурлаар Дэнжийн мянга, Дамбадаржаа, Толгойт, Шархад дэд төвүүдийн байршилд хүүхдийн цэцэрлэг, нийгмийн байгууламж, дулааны станц, автозам болон инженерийн шугам сүлжээний нөлөөлөлд өртөж байгаа газрын зах зээлийн үнийн судалгааны дүн болон иргэдийн хүсэлтийг танилцуулж, Нийслэлийн Засаг Даргын А/855 тоот захирамжаар нөлөөлөлд өртсөн газрын үнэлгээг иргэдтэй зах зээлийн үнийн дагуу зөвшилцөн нөхөн олговор олгохоор шийдвэр гаргуулан нөхөн олговрын зөрүүг олгоод байна.

## Байгаль орчны хамгааллын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн 1 үе шат нь байгаль орчны нөлөөллийн хувьд В категорийн төсөл гэж үнэлэгдсэн бөгөөд АХБ-ны хамгааллын бодлогын (ADB SPS 2009) дагуу Байгаль орчны суурь үнэлгээ ба БОМТ-г төслийн техник туслалцаа, бэлтгэл ажлын баг НЗДТГ-тай хамтран боловсруулж, 2013 оны 10 дугаар сард АХБ-нд хүлээлгэн өгсөн юм.

Байгаль орчны суурь үнэлгээ ба БОМТ-г инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах үе шатанд шинэчлэн засварлаж төслийн төлөвлөлт, бүрэлдэхүүн хэсгүүдэд гарсан өөрчлөлт, байгаль орчны холбогдолтой хууль эрхзүйн орчны өөрчлөлт, дотоодын зөвлөхийн боловсруулсан БОННУ-ний үр дүн зэргийг тусган оруулсан бөгөөд тайлангийн эцсийн хувилбар нь 2020 оны 5 дугаар сард АХБ-ны вэбсайт дээр байршсан.

Хөтөлбөрийн Байгаль орчны хяналт, үнэлгээний ерөнхий төлөвлөгөөг (EARF) шинэчлэн боловсруулж, тайлангийн эцсийн хувилбар нь 2020 оны 5 дугаар сард АХБ-ны вэбсайт дээр байршсан. Хөтөлбөрийн Байгаль орчны хяналт, үнэлгээний шинэчилсэн ерөнхий төлөвлөгөөнд байгаль орчны ангилал, төслийн үйл ажиллагааны болзошгүй нөлөөлөл, АХБ-ны хамгааллын бодлогод нийцсэн байгаль орчныг хамгаалах чиглэлийн баримт бичгүүдийг боловсруулж хэрэгжүүлэх, дотоодын хууль эрхзүйн шаардлагад нийцүүлж ажиллах төлөвлөлт зэрэг асуудлуудыг авч үзсэн.

Монгол Улсын Байгаль орны үнэлгээний тухай хуульд заасны дагуу хөтөлбөрийн 1-р үе шатны төсөлд БОАЖЯ-наас Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулан авсан бөгөөд уг дүгнэлтэд заагдсан чиглэл удирдамжийн дагуу Tranche 1 үе шатанд хамрагдах Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг ENVIRON ХХК 2013 онд боловсруулсан.

Хөтөлбөрийн 1 үе шатны инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын үе шатанд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн БОННУ-ний тайланд нэмэлт, тодотгол хийх ажлыг GREAT VISION ХХК гүйцэтгэж, 2018 онд БОАЖЯ-аар батлуулсан.

Байгаль орчны дотоод мониторингийн ажлын тайланг зургаа дахь удаагаа боловсруулж АХБ-нд хүргүүлсэн юм. Уг тайланд 2019 оны 5-р сараас 2020 оны 5-р сарыг хүртэлх хугацаанд Tranche 1 үе шатны хэрэгжилтийн явцад хийж гүйцэтгэсэн ажлуудыг нэгтгэн дүгнэсэн бөгөөд төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөлөл, тэдгээрийг бууруулах урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт, үр дүн зэргийг тусган оруулсан. Төслийн хэрэгжилтийн явцад авч хэрэгжүүлсэн агаар, ус, хөрсний чанарт хийгдсэн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн үр дүнг нэгтгэн үнэлж, төслийн зүгээс байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл нь дунд зэргийн эрчимтэй бөгөөд бууруулах бүрэн боломжтой гэж дүгнэсэн.

Хөтөлбөрийн 1 үе шатны байгаль орчны хөндлөнгийн мониторингийн ажлыг хариуцан хийхээр дотоодын мэргэжлийн байгууллага болох “СЭС” ХХК сонгогдсон ба 2019 оны 5-р сард хийгдсэн гэрээний сунгалтаар 2020 оныг дуустал ажиллахаар болсон. Байгаль орчны хөндлөнгийн мониторингийн зөвлөх нь төслийн барилгын ажлын талбар дээр хөрс, ус, агаарын чанарын хэмжилт шинжилгээг хариуцан хийхээс гадна БОМТ-ний биелэлт хэрэгжилтэд хяналт тавьж, барилгын ажлын талбай дээрх зөрчил дутагдлыг илрүүлэн засч залруулах арга хэмжээг төлөвлөхөөс гадна жил тутмын хөндлөнгийн мониторингийн тайланг боловсруулан АХБ-нд хүргүүлж байна.

Хөтөлбөрийн 1 үе шатны Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн 2020 оны Тухайн жилийн БОМТ ба БОМТ-ийн Биелэлтийн тайлангуудыг тус тус боловсруулсан ба тэдгээр тайлан, төлөвлөгөөнүүд нь БОАЖЯ-аар хянагдан батлагдсан.

### Нийгэм болон жендерийн үйл ажилаагааны төлөвлөгөөний хэрэгжилт

Хөтөлбөрийн 1 үе шатны нийгмийн хамгааллын төлөвлөгөө нь нийт 17 үйл ажиллагаа, 48 шалгуур үзүүлэлтэйгээс 2020 оны 12-р сарын 31-ны байдлаар 10 үйл ажиллагааны 35 шалгуур үзүүлэлт хангагдсан ба иргэдийн уулзалтууд, мэдээлэл түгээх, иргэдийн өргөдөл гомдлыг барагдуулах, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр гэх мэт 7 үйл ажиллагаа, 13 шалгуур үзүүлэлт хэрэгжүүлэх шатанд байна.

Мөн жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөө 11 үйл ажиллагаа, 15 шалгуур үзүүлэлттэйгээс 7 үйл ажилгааны 11 шалгуур үзүүлэлт хэрэгжилтийн шатандаа, 3 үйл ажиллагааны 4 шалгуур үзүүлэлт хүлээгдэж байна.

**Иргэдийн оролцоог хангах, иргэдэд мэдээлэл хүргэх.** Төслийн 1-р үе шатны хүрээнд 25 удаагийн иргэдийн уулзалт зохион байгуулагдаж, нийт 471 хүн оролцов. Үүнд, хот төлөвлөлт, дэд төвийг блокоор хөгжүүлэх тухай, болон “Дэд төвийн хөгжилд иргэдийн оролцоо” салбар уулзалтууд, иргэд болон хороодын засаг дарга, хэсгийн ахлагчдад төслийн явцын танилцуулга уулзалтууд зохион байгуулагдлаа.



Үүнээс, төслийн явцын мэдээлэл хүргэх хүрээнд Баянхошуу, Сэлбэ дэд төвийн хороодын засаг дарга, нийгмийн ажилтан, болон хэсгийн ахлагчдад төслийн явцын танилцуулга уулзалт хийж, дэд төвийн бүтээн байгуулалтын ажлуудын явцын танилцуулга, хот төлөвлөлтийн хүрээнд хийгдэж буй ажлууд, жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих сургалт, хөтөлбөрүүд, нийгмийн чиглэлийн төсөл хөтөлбөрүүд, боломжуудыг танилцууллаа. Нийт 2 удаагийн уулзалтанд 34 хүн хамрагдаж, бүтээн байгуулалтын явцтай холбоотой асуултуудын тухай асуултуудад хариулт авав.



Баянхошуу дэд төвд хийгдэж буй дулааны шугам сүлжээ болон замын ажил, үерийн хамгаалал сувгийн ажил болон 20 айлын Орлогод нийцсэн орон сууц загвар төслийн явцын талаарх мэдээллийг бэлтгэж иргэдэд хүргэв. Нийт 67 өрхөд төслийн явцын мэдээлэл, анхааруулах санамж болон өргөдөл гомдлын системийн талаарх мэдээллийг хүргэв.



Мөн түүнчлэн Баянхошуу дэд төвд баригдаж буй 20 айлын Орлогод нийцсэн орон сууц загвар төслийн нөлөөлөлд өртсөн 5 өрхийн 6 гишүүнд төслийн явцын танилцуулга уулзалтыг зохион байгуулж, барилгын батлагдсан нарийвчилсан зураг төслийг танилцуулж, иргэдийн асуултанд хариулт өгөв. Нийт 6 иргэн хамрагдлаа.

**ТА-9421:** Мэдээлэл холбооны технологийг ашиглан гэр хорооллын иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор хэрэгжүүлсэн техникийн туслалцааны төслийн хүрээнд Виртуал платформыг үүсгэж бий болгосон газарзүйн мэдээллийн сан болон шинэ дэд төв вебсайтыг иргэдэд нээлттэй ашиглах боломжийг бүрдүүлсэн. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдэд хэрэгцээтэй мэдээлэл хүргэх зорилгоор Баянхошуу болон Сэлбэ дэд төвийн Бизнес Инкубатор төвд ”Иргэдийн мэдээллийн төв”-ийн өрөөг холбогдох техник хэрэгсэл болон тавилга төхөөрөмжөөр тоноглон иргэдэд 2020 оны 3-р сараас нээлттэй ажиллуулж эхлэв. 2020 оны 12-р сарын 20-ны байдлаар нийт 242 иргэнд төслийн явц, хот байгуулалт, жижиг дунд бизнесийн судалгаа, түрээсийн байр, ажлын байр болон виртуал платформ болон гар утасны апплэйкэшн ашиглан төслийн явцын мэдээлэл авах тухай мэдээллүүдийг хүргэлээ. Иргэдийн мэдээллийн төвийг түшиглэн Миний гэр хүүхдийн ном сан ажиллаж байгаа бөгөөд Баянхошуу дэд төвийн нийт 130 хүүхэд бүртгэлтэй бөгөөд тогтмол үйлчүүлдэг болов. 2020 оны байдлаар номын санд 6 удаагийн кино хэлэлцүүлэг, 3 удаагийн номын хэлэлцүүлэг болж, нийт 90 хүүхэд хамрагдав.



**Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, иргэдийг чадваржуулах.** Энэ чиглэлээр 2020 оны 2-4 сарын хооронд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн нийт 702 жижиг дунд бизнес эрхлэгчдээс хэрэгцээ тодорхойлох судалгаа авлаа. Судалгаанаас товч харахад дийлэнх нь бичил буюу өрхийн бизнес эрхлэгчид байсан бөгөөд бизнесээ өргөжүүлэх зээлд хамрагдахад хүндрэлтэй, санхүүгийн дэмжлэг шаардлагатай, тоног төхөөрөмж дутмаг гэх мэт нийтлэг хэрэгцээ байдаг нь харагдав. Эдгээр судалгаанын үр дүнд тулгуурлан Төсөл Хэрэгжүүлэх нэгж дараах хөтөлбөрүүдтэй Хамтын Ажиллагааны Санамж бичгийг байгуулж, дэд төвийн иргэдэд шаардлагатай сургалт, үйл ажиллагааг хамтран зохион байгуулав.

- Азийн Сангийн Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн төв
- Хөгжлийн Шийдэл ТББ, Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх “BEST” хөтөлбөр
- Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, Эрдэс Баялаг, Түүхий Эдийн Иж бүрэн санаачилга “ЭТИС” хөтөлбөр



2020 оны 12-р сарын 20-ны өдрийн байдлаар Хөгжлийн Шийдэл ТББ, BEST хөтөлбөртэй хамтран 2 удаагийн бизнесийн онлайн сургалтанд 94 хүн, 1 удаагийн танхимын сургалтанд 14 хүн, Азийн


Сангийн Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвийн үйл ажиллагааны хүрээнд 26 онлайн, 80 удаагийн танхимын сургалтанд давхардсан тоогоор нийт 1300 иргэн хамрагдлаа.

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага, ЭТИС хөтөлбөрийн хүрээнд нэг удаагийн төслийн сургалт болон ганцаарчилсан зөвлөгөөг зохион байгуулж, нийт 29 бизнес эрхлэгчийг хамруулснаас гадна “Санхүүжилт ба Бизнесээ өргөжүүлэх нь” өдөрлөгийг олон улсын төсөл хөтөлбөрүүд болон банк санхүүгийн байгууллагуудтай хамтран Баянхошуу Бизнес Инкубатор төвд зохион байгуулсан бөгөөд нийт 100 гаруй иргэн оролцож, мэдээлэл авч, ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдав. Уг өдөрлөгөөр иргэдэд зээлд хамрагдах боломж, холбогдох зээлийн болон чадваржуулах сургалт зохион байгуулдаг банк санхүүгийн байгууллагууд болон олон улсын төсөл хөтөлбөрүүд хамтран оролцож, мэдээлэл болон ганцаарчилсан зөвлөгөөг өглөө.



**2020 онд Баянхошуу Бизнес Инкубатор төв нээлтээ хийж, иргэдэд үйлчилж эхэллээ.**

- Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, Баянхошуу салбар, нийт 198 төрлийн төрийн үйлчилгээ
- Нэгдсэн үйлчилгээний төвийн салбар
- Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газар, инкубатор өрөөнд бойжигчид
- Төсөл хэрэгжүүлэх нэгж, Иргэдийн мэдээллийн төв
- Азийн Сангийн Бизнес Эрхлэгч эмэгтэйчүүдийн төв, бизнес эрхлэгч эмэгтэйчүүд
- Дэлхийн Зөн, Төгсөлтийн аргачлал-600, зорилтот өрхийн бүлэг
- Дэд төвийн хороодын бизнес эрхлэгч иргэд(үсчин, үндэсний гутал хийдэг гэр бүл) гэх мэт байгууллага, иргэд үйл ажиллагаагаа явуулж, бизнесээ хөгжүүлж байна. Баянхошуу Бизнес Инкубатор төв ашиглалтанд орсноор нийт 37 хүн байнгын ажлын байртай боллоо.



Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй Ур чадварыг хөгжүүлэх төслийн үйл ажиллагаа 2 дахь жилдээ амжилттай хэрэгжлээ. 2020 оны үйл ажиллагааны хувьд

- Төслийн 1,2,3-р үе шатны Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүдийн нийт 23 хорооны засаг дарга, хэсгийн ахлагч, нийгмийн ажилтнуудад төслийн танилцуулга уулзалтыг зохион байгуулж, иргэдийг идэвхтэй оролцуулах тал дээр хамтран ажиллаа. Үүний үр дүнд, нийт 400 гаруй барилгын чиглэлээр ажилладаг, амьдралаас олж авсан мэдлэг туршлагатай, мэргэжлийн үнэмлэхгүй иргэдийн бүртгэлийг хийлээ.
- Нийт бүртгэгдсэн иргэдээс төслийн хүрээнд 105 иргэн барилгын 7 чиглэлээр Ур чадварын үнэлгээнд орж, 83 иргэн тэнцэж, мэргэжлийн гэрчилгээтэй боллоо.



- Төслийн 1-р үе шатны 16 гүйцэтгэгч компаний ажилчдад төслийн танилцуулга уулзалтыг хийж, хамтран ажиллах тухай ярилцлаа. Үүний үр дүнд, 3 гүйцэтгэгч компаний 10 ажилтан ажлын байран дээрх дадлагажуулагчийн 5 хоногийн сертификаттай сургалтанд сууж, төгсөн оюутнууд болон иргэдийн ажлын байран дээрх богино хугацааны сургалтыг удирдах чадамжтай боллоо.



- Мөн төслийн хүрээнд “Барилгын салбарт эмэгтэйчүүд” өдөрлөгийг Барилгын Политехникын коллежтай хамтран зохион байгууллаа. Нийт Баянхошуу дэд төвийн 3 сургуулийн 28 охид оролцож, барилгын чиглэлүүдээр дадлага хийж, лекц сонсож, мөн шаардлагатай ганцаарчилсан зөвлөгөөг авлаа.



Мөн Сэлбэ дэд төвийн 240 хүүхдийн цэцэрлэг 2020 оны 9-р сард ашиглалтанд орж, үйл ажиллагаагаа эхлүүллээ. Ингэснээр, тус дэд төвийн цэцэрлэгт хамрагдаж чаддаггүй байсан 265 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж, нийт 38 багш ажилчид ажлын байртай боллоо.



### Иргэдийн санал, гомдол түүнийн шийдвэрлэлтийн байдал

2020 онд Баянхошуу, Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор нийт 58 өргөдөл гомдол /Баянхошуу-19, Сэлбэ-39/ ирсэн байгаагаас газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой 5, газраа байраар солих 1, газрын үнэлгээ нөхөн олговортой холбоотой 2, түр суурьших байранд байрлах 3, дулаан цэвэр бохирын шугамд холбогдох 9, инженерийн байгууламжийн барилгын ажлын талаар 28, бүтнээр хамрагдах хүсэлтэй 1, цэцэрлэгт хүүхдээ хамруулах хүсэлт 3, нөхөн сэргээлттэй холбоотой 4, эко 00-ын талаар 2 өргөдөл гомдол ирсэн байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа нь 5 – 30 хоног байна. Нийт 35 өргөдлийг иргэний талд шийдвэрлэсэн бол 22 өргөдөлд шийдвэрлэх боломжгүй хариу өгсөн байна. Нийт өргөдөл гомдлын 98%-ыг шийдвэрлээд байна.

### САНХҮҮЖИЛТЫН ЯВЦ

Хөтөлбөрийн 1-р үе шатны санхүүжилт 2020 оны 12 сарын 31-ны байдлаар АХБ-ны МОН-3099 (COL) зээлийн эх үүсвэрийн 22.50 сая ам.доллараас 16.92 сая ам.долларыг дэд төвүүдэд байригдаж буй нийгмийн барилга байгууламжийн барилга угсралтын ажилд, МОН-3098 (OCR) зээлийн эх үүсвэрийн 27.5 сая ам.доллараас 20.62 сая ам.долларыг дэд төвүүдийн инженерийн шугам ёулжээний барилга угсралтын ажилд, ЕХОБ-ны FI'83097 зээлийн эх үүсвэрийн 22.01 сая ам.доллараас 17.32 сая ам.долларыг усан сан, цэвэр бохир усны шугам сүлжээний ажилд, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын 33.15 сая ам.доллараас 28.16 сая ам.долларыг газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговор, түний дэмжлэг болон инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний хамтарсан санхүүжилттэй гэрээт ажлуудад зарцуулсан байна. Нийт санхүүгийн зарцуулалт 79.66%-тай байна.

Буцалтгүй тусламжийн МОН-0380 төслийн санхүүжилтыг 2019 оны 11 сарын 21-ны өдрөөр дуусгавар болж үлдэгдэл 1,008.00 долларыг зарцуулаагүй байна.

(сая ам.доллар)

Эх үүсвэр	Санхүүжилт		Зарцуулалт	%
	Анхны төлөвлөсөн	Шинэчлэгдсэн		
<b>АХБ-ны санхүүжилт</b>				
МОН-3099 (COL)	22.5	22.5	16.92	75.20%
МОН-3098 (OCR)	27.5	27.5	20.63	75.02%
МОН-0380 (COL)	3.7	3.7	3.69	99.73%
<b>Дэд дүн</b>	<b>53.7</b>	<b>53.7</b>	<b>41.24</b>	<b>76.80%</b>
НЗДТГ-ын төсөв	22.44	33.15	28.16	84.95%
ЕХОБ-ны санхүүжилт FI'83097	28.38	22.01	17.32	78.69%
<b>Нийт</b>	<b>104.52</b>	<b>108.86</b>	<b>86.72</b>	<b>79.66%</b>

2020 онд батлуулсан төсвийн гүйцэтгэл дараах байдалтай байна.

(төгрөг)



Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

Эх үүсвэр	2020 оны төсөв	Гүйцэтгэл	%
<b>АХБ-ны санхүүжилт</b>			
МОН-3099 (COL)	25,247,604,200.00	23,360,943,617.34	92.53%
МОН-3098 (OCR)	10,295,600,000.00	9,871,659,180.96	95.88%
МОН-0380 (COL)	-	-	
<b>Дэд дүн</b>	<b>5,543,204,200.00</b>	<b>33,232,602,798.30</b>	<b>93.50%</b>
НЗДТГ-ын төсөв	23,307,401,636.00	23,306,401,636.00	99.99%
ЕХОБ-ны санхүүжилт ҮГ'83097	13,033,600,000.00	13,013,624,559.41	99.85%
<b>Нийт</b>	<b>71,884,205,836.00</b>	<b>69,552,628,993.71</b>	<b>96.76%</b>

**ХӨТӨЛБӨРИЙН ХОЁР ДУГААР ҮЕ ШАТ – ДАМБАДАРЖАА, ДЭНЖИЙН МЯНГА ДЭД ТӨВ****ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Хөтөлбөрийн 2-р үе шатны хүрээнд (i) хотын хойд хэсэгт байрладаг Дамбадаржаа, Дэнжийн дэд төвүүдэд хотын дэд бүтцийг шинэчлэх өргөтгөх, Баянхошуу, Сэлбэ дэд төвд нэмэлт хөрөнгө оруулалт хийх, (ii) нийгэм эдийн засгийн барилга байгууламж барих, (iii) чадавх бэхжүүлэх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн 1-үе шатны дэд төвүүдээс гадна хөтөлбөрийн 2-р үе шатнаас нийт 55,331 хүн (13,702 өрх) үр шим хүртэнэ. Үүнээс Дамбадаржаад буюу Сүхбаатар дүүргийн 16, 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 109,82 га талбайд 18,349 хүн 1725 өрх, Дэнжийн мянга буюу Чингэлтэй дүүргийн 10-13 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 62.27 га талбайд 36,982 хүн, 8840 өрх амьдарч байна.

Үе шат 2-ын зээлийн хэлэлцээрийг 2017 оны 12 сарын 6-нд батлуулсан.

*Төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө*

(сая ам.доллар)

Эх үүсвэр	Санхүүжилт	Эзлэх хувь
АХБ-ны санхүүжилт		
МОН-3025 (COL)	29.24	24.14
МОН-3026 (OCR)	37.11	30.63
<b>Дэд дүн</b>	<b>66.35</b>	<b>54.77</b>
НЗДТГ-ын төсөв	35.15	29.02
ЕХОБ-ны санхүүжилт FГ'83097	19.64	16.21
<b>Нийт</b>	<b>121.14</b>	<b>100</b>

(сая ам.доллар)

№	Үндсэн үйл ажиллагаа	Төлөвлөсөн
<b>А. Суурь зардал</b>		<b>103.46</b>
<i>I</i>	<i>Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх</i>	<i>80.33</i>
1.1	Автозам сайжруулах	30.69
1.2	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, үйлчилгээг сайжруулах	16.74
1.4	Дулааны шугам сүлжээ, үйлчилгээг сайжруулах	32.90
<i>II</i>	<i>Эдийн засгийн болон нийгмийн байгууламжийг нэмэгдүүлэх</i>	<i>18.84</i>
<i>III</i>	<i>Байгууллагыг чадавхижуулах</i>	<i>4.29</i>
<b>Б. Магадлашгүй ажил</b>		<b>11.06</b>
<b>В. Хэрэгжүүлэх үеийн санхүүгийн хураамж</b>		<b>6.62</b>
<b>Нийт дүн</b>		<b>121.14</b>

Хөтөлбөрийн 2-р Үе шатыг дараах бүрэлдэхүүн хэсгүүдээр хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх
2. Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд
3. Төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх

Хөтөлбөрийн 2-р үе шатны хүрээнд Дамбадаржаа, Дэнжийн мянга төвүүдийн бүтээн байгуулалтийг хийх бөгөөд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн нэмэлт бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ 2-үе шатны хэрэгжилтийн явц 24,75% байна.

Үйл ажиллагаа	Хуваарилсан жин	Бодит явц	Жинлэсэн явц



Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

<b>ГЧНШ</b>	<b>17.50%</b>	<b>50.42%</b>	<b>7.70%</b>
Төлөвлөлт	8.75%	49.73	4.35
Хэрэгжүүлэлт	8.75%	51.12	4.47
<b>ХАА</b>	<b>17.50%</b>	<b>38.56%</b>	<b>6.75%</b>
Барилгын ажил	14.86%	30.34%	4.51%
Зөвлөх үйлчилгээ	0.29%	13.28%	0.04%
Бараа	2.35%	93.61%	2.20%
<b>Барилга угсралт</b>	<b>60.40%</b>	<b>13.36%</b>	<b>8.07%</b>
Зураг төсөл боловсруулалт	0.40%	44.39%	0.18%
Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх	32.71%	20.01%	6.55%
Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд	17.20%	0.36%	0.06%
Усны барилга байгууламжууд	10.49%	12.23%	1.28%
<b>Зөвлөх үйлчилгээ</b>	<b>4.60%</b>	<b>24.22%</b>	<b>1.11%</b>
<b>Нийт</b>	<b>100.00%</b>		<b>24.75%</b>


Хөтөлбөрийн 2-р үе шатны хүрээнд Дэд төвүүдийн хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийн тоймыг дараах хүснэгтээс харна уу


Барилга байгууламж	Баянхошуу дэд төв	Дамбадаржаа дэд төв	Дэнжийн мянга дэд төв
<b>Автозам</b>	-	2.8 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалтын явц - 57%	3.4 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалтыг эхлүүлэхээр бэлдэж байна
<b>Цахилгааны шугам сүлжээ</b>	-	12 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалтын явц - 26%	29 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалтыг эхлүүлэхээр бэлдэж байна.
<b>Дулаан хангамжийн шугам сүлжээ</b>	3 км төлөвлөснөөс 3 км хийгдсэн	3.2 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалтын явц - 57%	4.2 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалтыг эхлүүлэхээр бэлдэж байна
<b>Ус хангамжийн шугам сүлжээ</b>	-	5 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалтын явц - 57%	8.1 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалтыг эхлүүлэхээр бэлдэж байна
<b>Ариутгах татуургын шугам сүлжээ</b>	-	4.6 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалтын явц - 57%	5.7 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалтыг эхлүүлэхээр бэлдэж байна
<b>Үерийн хамгаалалтын далан суваг</b>	-	5 км төлөвлөсөн Зураг төслийг боловсруулсан. ХАА-ны явц - %	-
<b>Талбайн тохижилт</b>	Зураг төслийг боловсруулсан. ХАА-ны явц - 25%	-	-
<b>Орон сууц</b>	Зураг төслийг боловсруулсан.	-	-

	ХАА-г зохион байгуулж гэрээ байгуулсан.		
<b>Цэцэрлэгт хүрээлэн</b>	Зураг төслийг боловсруулсан. ХАА-ны явц - 84%	-	-
<b>Дулааны станц</b>	-	Зураг төслийн боловсруулалтын явц - 365	Зураг төслийн боловсруулалтын явц - 10%
<b>Мэдээлэл холбооны үйлчилгээний төв</b>	-	Зураг төслийн боловсруулалтын явц - 26%	Зураг төслийн боловсруулалтыг эхлүүлэхээр бэлдэж байна
<b>Олон нийтийн хөгжлийн төв</b>	Зураг төслийг боловсруулсан. ХАА-ны явц - 80%	-	-
<b>Цэцэрлэг</b>	Зураг төслийг боловсруулсан. ХАА-ны явц - 90%	150 хүүхдийн цэцэрлэг Зураг төслийн боловсруулалтын явц - 46%	240 хүүхдийн цэцэрлэг Зураг төслийн боловсруулалтын явц - 30%
<b>Хүчирхийллийн эсрэг хамгаалах байр</b>	Зураг төслийг боловсруулсан. ХАА-ны явц - 47%	-	-
<b>Гал унтраах ангийн барига</b>	Зураг төслийн боловсруулалтын явц - 64%	-	-
<b>Спорт цогболбор</b>	Зураг төслийг боловсруулсан. ХАА-ны явц - 6%	Зураг төслийн боловсруулалтын явц - 20%	-

### ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ

Хөтөлбөрийн 2 үе шатанд нийт 4 төрлийн эх үүсвэрээс 44 багц худалдан авалт (35 барилгын ажил, 3 бараа материал ханган нийлүүлэх, 6 зөвлөх үйлчилгээний) зохион байгуулахаар төлөвлөснөөс 8 барилгын ажил, 2 зөвлөх үйлчилгээ, 1 бараа худалдан авах үйлчилгээг зохион байгуулаад байгаа бөгөөд худалдан валтын ажлын явц 38,56%-тай байна.





Одоогийн байдлаар дараах худалдан ажлуудын худалдан авалтын үйл ажиллагааг эхлүүлээд байна.

№	Ажлын нэр	Худалдан авалтын явц
1	Баянхошуу дэд төвийн Цэцэрлэг	Тендерийн нээлт хийсэн
2	Баянхошуу дэд төвийн Олон нийтийн хөгжлийн төв	Тендерийн нээлт хийсэн
3	Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг төвийн байр	Тендерийн нээлт хийсэн
4	Баянхошуу дэд төвийн Цэцэрлэгт хүрээлэн	Тендерийг дахин зарлан үнэлгээний тайланг АХБ-нд хянуулахаар хүргүүлсэн
5	Баянхошуу дэд төвийн Ногоон байгууламж	Тендерийн баримт бичгийг эцэслэн боловсруулсан.
6	Хөтөлбөрийн 3-р үе шатны инженерийн нарийвчлосан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	Гэрээний хэлэлцээр хийж байна.

Энэхүү үе шатны хүрээнд байгуулсан гэрээний хэрэгжилтийн мэдээллийг **Хавсралт 4-т** үзүүлэв.

### БҮРЭЛДЭХҮҮН 1. АВТО ЗАМ БОЛОН ХОТЫН ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ

Тайлангийн хугацаанд хөтөлбөрийн I үе шатанд боловсруулагдсан барилга угсралтын ажлуудын нарийвчилсан зураг төслийн дагуу 2 барилгын ажил гүйцэтгэгдэж дууссан байна.

№	Багцын дугаар	Ажлын нэр	Гүйцэтгэгч	Ажлын явц
<b>АХБ-ны санхүүжилт</b>				
1	GWD 14	Сэлбийн хөрсний ус зайлуулах 2,2 км шугамын ажил	Набсан ХХК, Тэргүүн инвест ХХК, Тэгш плант ХХК түншлэл	100%
2	GWD 11	Сэлбийн хөрсний ус зайлуулах 1,3 км шугамын ажил	Вайт Феоникс ХХК	100%
3	SHS	Нүүлгэн шилжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх 126 айлын түрээсийн орон сууц	Монсон констракшн ХХК	0%
4	BHF06B	Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, дулааны даралт өргөх, насүс станц, ус дулаан дамжүүлэх төв, дулааны шинэ шугамын зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралтын ажил	Жанхан-Одкон, КДАЙЧЕСИ түншлэл	94.40%



<b>ЕХОБ-ны санхүүжилт</b>				
5	HSSC-A	Шинэ суурьшлын бүсэд хийгдэх сайжруулсан нүхэн жорлон суурилуулах	Хэмжил зүй ХХК	43%
6	HSSC-B	2-р хэлхээний дулаан хангамж, хэрэгцээний халуун ус, цэвэр усны шугам сүлжээний угсралтын ажил	Бумбод ХХК, Алтайн үндэс ХХК түншлэл	43.23%
7	WSC16B	Шархад дэд төвийн Цайз эко хотхон хорооллыг төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын шугам, халуун, дулааны шугам, болон цахилгаан хангамжийн шугамд холбох зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралтын ажил	ЧММ ХХК, Шандонг идастри пайпи ХХК түншлэл	75.70%
8	USF	Морингийн даваа орчмын шинэ суурьшлийн бүсийг инженерийн хангамжийн шугам сүлжээнд холбох	Набсан ХХК, ЧММ ХХК, Санжат ХХК түншлэл	0%

Хөтөлбөрийн үе шат II-ийн хүрээнд баригдах дараах барилга байгууламжуудын нарийвчилсан зураг төслийг боловсруулан улсын экспертээр батлуулаад байна. Үүнд:

- Морингийн даваа орчмын шинэ суурьшлийн бүсийг инженерийн хангамжийн шугам сүлжээнд холбох (USF)
- Дамбадаржаа дэд төвийн үерийн хамгаалалтын суваг (DAFPE)
- Дамбадаржаа дэд төвийн авто зам болон инженерийн хангамжийн шугам сүлжээний ажил (DARI)
- Нүүлгэн шилжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх 126 айлын түрээсийн орон сууц (SHS)

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд гүйцэтгэгдэн улсын косщмисст хүлээлгэн өгсөн барилгын зургыг **Хавсралт 5-т** үзүүлэв.

Дээрх хүлээлгэн өгсөн барилгуудын ажлаас дараах үр дүн гарч байна.

- **Сэлбэ дэд төвийн 4.1 км хөрсний ус зайлуулах шугам хоолойн барилга угсралтын ажлыг гүйцэтгэснээр хөрсний усны түвшин доошилж тухайн хэсэгт Хөтөлбөрийн 1-р үе шатны хүрээнд хийгдэж байсан инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил бүрэн хийгдэж дууссан.**
- **Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, дулааны даралт өргөх, насүс станц, ус дулаан дамжуулах төв, дулааны шинэ шугамын зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дараах үр дүн гараад байна. Үүнд:**

Дулааны 11и магистраль шугам хоолойг өргөтгөж, шинэчлэх ажлыг хийснээр Ханын материал, Баянхошуу орчмын барилга байгууламж, хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох нөхцөл бүрдэж, шинээр дулааны магистраль шугам Баянхошуу дэд төв рүү татах боломж үүссэн.

**Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, дулааны даралт өргөх, насус станць ус дулаан дамжүүлах төв, дулааны шинэ шугамын зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралтын ажил**

<b>Хүчин чадал / үзүүлэлт:</b>	Насос станцын барилга - 3x650 м <sup>3</sup> /ц хүчин чадалтай; Дулааны шугам /2ф400мм/ - 450м; Дулааны шугам /2ф500мм/ - 1900м; Дулааны шугам /2ф600мм/ - 650м; УДДТ барилга - 2ш; ХТП барилга - 2ш;
<b>Гүйцэтгэгч:</b>	БНСУ-ын “Жангхан Инженеринг” ХХК, “КDHЕС” ХХК, болон Монгол Улсын “Одкон Холдинг” ХХК-иудын түншлэл
<b>Гэрээний дугаар:</b>	<b>ВНФ06В – 94.40%</b>

**Өргөлийн насос станцын барилга**



**Дулааны шугамын төлөвлөлт**



**Өргөлийн насос станцын тоноглол**



**ЦТП-ын барилга**



**2-р хэлхээний дулаан хангамж, хэрэгцээний халуун ус, цэвэр усны шугам сүлжээний угралтын ажил**

<b>Хүчин чадал / Үзүүлэлт:</b>	СБД-н 14-р хороо, Өрхийн эмнэлгийн дулаан хангамжийн системд холбох - 500м 35-р сургуулийг дулаан хангамжийн системд холбох - 1315м 51-р цэцэрлэгийг дулаан хангамжийн системд холбох-615м Түр суурьшуулах 50 айлын орон сууцыг дулаан хангамжийн системд холбох-200м 280-р цэцэрлэгийг дулаан хангамжийн системд холбох-900м Сэлбийн бизнес инкубатор, МСҮТ-ийг дулаан хангамжийн системд холбох-1085м Дулааны узель угсрах-8ш
<b>Гүйцэтгэгч:</b>	Бумбод ХХК болон Алтайн үндэс ХХК түншлэл
<b>Гэрээний дугаар:</b>	HSSC-B – 40.62%





## БҮРЭЛДЭХҮҮН 2. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Хөтөлбөрийн үе шат II-ийн хүрээнд баригдах дараах барилга байгууламжуудын нарийвчилсан зураг төслийг боловсруулан улсын экспертизээр батлуулаад байна. Үүнд:

- 650 хүний суудалтай Спорт Цогцолбор /Баянхошуу дэд төв/ (BDSC-BKH)
- 240-н хүүхдийн цэцэрлэгийн барилга /Баянхошуу дэд төв/ (ASKG-BKH)
- Олон Нийтийн Хөгжлийн төв /Баянхошуу дэд төв/ (DDCD-BKH)
- 2га талбайд Цэцэрлэгт хүрээлэн /Баянхошуу дэд төв /Баянхошуу дэд төв/ (DDPK-BKH)
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байр (SFS)
- Нүүлгэн шилжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх 126 айлын түрээсийн орон сууц (SHS)

Мөн дараах нийгмийн барилга байгууламжуудын зураг төслийн ажлыг гүйцэтгэж байгааг хүснэгтэд харуулав.

№	Барилга, Дэд төвүүд	Хийгдэж буй ажлууд
1.	Спорт Цогцолбор /Дамбадаржаа дэд төв/	Нарийвчилсан зураг төслийн бодит явц – 20% - Эх загвар зураг хянах – 100% - Барилгын иж бүрэн ажлын зураг хянах – 0% - Гадна шугам сүлжээний зураг хянах – 0%
2.	Олон Нийтийн Хөгжлийн төв /Дамбадаржаа дэд төв/	Нарийвчилсан зураг төслийн бодит явц – 20% - Эх загвар зураг хянах – 100% - Барилгын иж бүрэн ажлын зураг хянах – 0% - Гадна шугам сүлжээний зураг хянах – 0%
3.	150 хүүхдийн цэцэрлэгийн барилга /Дамбадаржаа дэд төв/	Нарийвчилсан зураг төслийн бодит явц – 46% - Эх загвар зураг хянах – 100% - Барилгын иж бүрэн ажлын зураг хянах – 80% - Гадна шугам сүлжээний зураг хянах – 50%
4.	240 хүүхдийн цэцэрлэгийн барилга /Дэнжийн мянга дэд төв/	Нарийвчилсан зураг төслийн бодит явц – 30% - Эх загвар зураг хянах – 100% - Барилгын иж бүрэн ажлын зураг хянах – 50% - Гадна шугам сүлжээний зураг хянах – 0%
5.	Цэцэрлэгт хүрээлэн /Дэнжийн мянга дэд төв/	Нарийвчилсан зураг төслийн бодит явц – 36% - Эх загвар зураг хянах – 100% - Барилгын иж бүрэн ажлын зураг хянах – 80% - Гадна шугам сүлжээний зураг хянах – 0%
6.	Гал унтраах ангийн барилга	Нарийвчилсан зураг төслийн бодит явц – 64% - Эх загвар зураг хянах – 100% - Барилгын иж бүрэн ажлын зураг хянах – 100% - Гадна шугам сүлжээний зураг хянах – 100% - ТББ-ийн 4,6 хэсгийг хянах – 10% - Экспертизээр батлуулах – 10%

## БҮРЭЛДЭХҮҮН 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

### Төслийн удирдлагын дэмжлэг үзүүлэх

Төсөл нь худалдан авалт, газар чөлөөлөлт, барилга угсралт гэсэн үндсэн 3 чиглэлийн үйл ажиллагаагаар дамжин хэрэгжих бөгөөд төслийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх 5 төрлийн зөвлөх үйлчилгээтэй байхаар төлөвлөгдсөний дагуу хэрэгжиж байна.

Хөтөлбөрийн зорилго, зорилтод хүрэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Төсөл 1-ийн хүрээнд, (i) Төслийн удирдлагын дэмжлэг үзүүлэх; (ii) Хөтөлбөрийн 2, 3-р үе шатны нарийвчилсан зураг төсөл боловсруулах; (iii) Хөндлөнгийн байгалт орчны мониторинг хийх; (iv) Хөндлөнгийн газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн мониторинг хийх; (v) олон нийтийн оролцоог хангах гэсэн 6 зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан ажиллахаар төлөвлөснөөс 2 зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

### Зөвлөх үйлчилгээ

- i. Хөтөлбөрийн 2-р үе шатны инженерийн зураг төсөл боловсруулах

Хөтөлбөрийн 2-р үе шатны инженерийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг 2018 оны 11 сарын 16-нд ДМЕК болон Боди консорциум Ёошин ассосайшнтай хамтарсан түншлэлтэй гэрээ байгуулан хэрэгжүүлж эхлэсэн. Гэрээний хүрээнд зураг төсөл боловсруулах судалгааг хийн



## Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

зураг төслийн боловсруулж мөн барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих ажлуудыг багтаасан Нийт хэрэгжүүлэх зураг төслийн ажлыг шаардлагын дауу 4 янзаар эрэмблэн зураг төслийн ажлыг эхлүүлсэн бөгөөд зураг төслийн ажлын явц 44,39%-тай байгаа бөгөөд зөвлөх үйлчилгээний ажлын явц 25,32%-тай байна.

Зураг төсөөлвсруулалтын ажил удаашралтай байгаа нь холболгдо дулааны болон цахилгаан хангамжийн байгууллагуудаас техникийн нөхцөл авах үйл явц маш удаан хийгдэж байгаа бөгөөд зарим барилга байгууламжийн байршил газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаатай холбоотой удаашраад байгаатай холбоотой байна.

### ii. Төслийн удирдлагын дэмжлэг үзүүлэх

Төслийн удирдлагын дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээг Интерсонтинал консалтантс, Технокрафт, Тэнхлэг зууч, Ай Си Ти- Сайн консалтинг ХХК-уудын түншлэлтэй 2019 оны 1 сарын 4-нд гэрээ байгуулсан. Зөвлөх үйлчилгээний хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэхээр ажлын даалгаварт тусгасан. Үүнд: i. Хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, ii. Хотын төлөвлөлт болон дэд төвүүдийн дахин төлөвлөлтөд дэмжлэг үзүүлэх, iii. Олон нийтийн оролцоог хангах болон ЖДҮ-ийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, iv. Хөтөлбөрийн 3-үе шатны ТЭЗҮ боловсруулах.

Дээрх ажлууды хүрээнд хяналт тавин хамтран ажиллаж байгаа бөгөөд зөвлөх үйлчилгээний үйл ажиллагааны хэрэгжилт 42,7%-тай байна

## **АХБ-ны хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх**

### **Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц**

Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нийт 7 төлөвлөгөө, 4 нийцтэй байдлын тайлан боловсруулж АХБ-аар баталгаажуулахаас 6 төлөвлөгөө болон 2 зохистой байдлын тайлан боловсруулаад байна. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө болон зохистой байдлын тайланг боловсруулахад тухайн сонгосон байршил болон амьдарч буй иргэдтэй зөвлөлдөх уулзалтууд хийх болон нөлөөлөлд өртөх магадлалтай иргэдээс нийгэм эдийн засгийн судалгаа авах шаардлагатай байдаг. Дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн КОВИД-19 цар тахал гарсны улмаас олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хориглосон тул эдгээр ажлуудыг хийх боломжгүй байдал үүсч хойшлуулах шаардлагатай болсон

Хөтөлбөрийн II үе шатанд хамаарах I үе шатны хүрээнд эхлүүлсэн Дамбадаржаа дэд төвийн цэцэрлэг, мэдээлэл холбооны нэгдсэн төв, Баянхошуу дэд төвийн үерийн суваг, цэцэрлэг, спорт цогцолбор, Баянхошуу уулын цэцэрлэгт хүрээлэн, Баянхошууны орлогод нийцсэн орон сууцны загвар байрны барилгын ажилд хамаарах 3 ажлын газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлуудыг бүрэн дуусгасан байна. Ингэснээр газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нийт ажлын явц тайлангийн хугацаанд 50.42%-д хүрсэн байна.

Мөн II үе шатанд хамаарах 3 байршлын газар чөлөөлөлтийн ажлын бэлтгэлийг хангаж газар чөлөөлөх хуулийн этгээдтэй зөвшилцөлд хүрсэн ба нөхөн олговор олгох захирамж гаргах болон газар эзэмших эрх олгох тухай тухай Нийслэлийн Засаг даргын захирамж гаргуулах, газар эзэмших эрхийг баталгаажуулах ажил хийгдэж байна.

Дамбадаржаа дэд төвийн хүрээнд Цэцэрлэгийн зориулалтаар 12 нэгж талбарын 17 айл өрхийг нүүлгэн шилжүүлсэн ба Нийслэлийн Засаг даргын 2020 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн А/863 дугаар захирамжаар 1,093,906,742₮-ийг нөхөх олговорт олгосон байна. Тухайн 17 айл өрхөд газар чөлөөлөлтийн ажил хийгдснээс хойш 6 сарын дараа дандан судалгаа явуулахад 10 айл 2-4 өрөө орон сууц худалдан авсан, 4 айл орон сууц болон өөр байршилд хашаа байшин давхар худалдан авсан, 2 айл орон сууц аваад мөн авто машин худалдан авсан, 1 айл гэр бүлийн гишүүд нь нөхөх олговороо хувааж авсан судалгаа гарсан байна.

Үүнээс үзвэл 17 айл өрхийн 16 айл нь үл хөдлөх хөрөнгө худалдан авсан мөн тээврийн хэрэгсэлтэй болсон байна.

### **Байгаль орчны хамгааллын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн 2 үе шат нь байгаль орчны нөлөөллийн хувьд В категорийн төсөл гэж үнэлэгдсэн бөгөөд АХБ-ны хамгааллын бодлогын (ADB SPS 2009) дагуу Tranche 2 үе шатны Байгаль орчны суурь үнэлгээ ба БОМТ-г төслийн менежментийн зөвлөх байгууллага (Dohwa Engineering) боловсруулж, 2016 оны 12-р сард АХБ-аар батлуулсан.

Хөтөлбөрийн 2 үе шатны инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах үе шатанд төслийн бүрдэл хэсгүүдэд тодорхой хэмжээний өөрчлөлт гарч, Дамбадаржаа, Дэнжийн 1000 дэд төвүүдээс гадна шинээр 4 барилгын ажлын талбар нэмэгдсэн тул Tranche 2 үе шатны Байгаль орчны суурь үнэлгээ ба БОМТ-ийг шинэчлэн засварлаж, тайлангийн эцсийн хувилбар нь 2020 оны 5 дугаар сард АХБ-ны вэбсайт дээр байршсан.

Монгол Улсын Байгаль орны үнэлгээний тухай хуульд заасны дагуу хөтөлбөрийн 2-р үе шатанд хамрагдах төслийн 6 байршилд БОАЖЯ-наас Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулан авсан бөгөөд уг дүгнэлтэд заагдсан чиглэл удирдамжийн дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ ба БОМТ боловсруулах ажлын мэргэжлийн байгууллага болох Эс И Си ХХК 2020-2021 онуудад хийж гүйцэтгэж байна. Уг ажлын хүрээнд хамрагдах 6 төслийн талбайд БОАЖЯ ба НБОАЖГ-аар Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулсан ба Морин Даваа, Баянхошуу-Ханын материалын төсөл хэрэгжих талбайд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгэн 2020 оны 4-р сард БОАЖЯ-аар батлуулсан. Дамбадаржаа, Дэнжийн 1000 дэд төвүүд ба Дамбадаржаа дулааны станцын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил хойшилсноос үүдэн тус дэд төвүүдийн БОННУ-ний тайланг 2021 оны 2-р улиралд багтаан боловсруулж дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

### Нийгэм болон жендерийн үйл ажилаагааны төлөвлөгөөний хэрэгжилт

Хөтөлбөрийн 2 үе шатны нийгмийн хамгааллын төлөвлөгөө нь нийт 15 үйл ажиллагаа, 30 шалгуур үзүүлэлтэйгээс 2020 оны 12-р сарын 31-ны байдлаар 11 үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ковид-19 цар тахлаас сэргийлэх карантины улмаас дэд Дамбадаржаа болон Дэнжийн мянга дэд төвийн иргэдэд төслийн Фэйсбүүк хуудас болон иргэдийн бүлгийн ахлагчдаар дамжуулан төслийн явцын мэдээллүүдийг хүргэв. 2020 оны 12-р сарын байдлаар иргэдийн 4 удаагийн уулзалтыг Дамбадаржаа дэд төвийн бүтээн байгуулалтын нөлөөлөлд өртсөн иргэдэд зохион байгуулж, нийт 112 иргэн хамрагдан, дэд төвд хийгдэхээр төлөвлөгдөж байгаа бүтээн байгуулалтын ажлууд, газар чөлөөлөх процесс хэрхэн явагдах тухай болон Ур чадварыг хөгжүүлэх төслийн танилцуулгуудтай танилцаж, асууж тодруулах зүйлсээ асуулаа.



Мөн холбогдох мэдээллийг бэлтгэн өрхүүдэд хүргүүлсэн бөгөөд нийт 63 өрхөд төслийн явцын мэдээллийг бэлтгэн хүргэв. Төслийн жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд охид эмэгтэйчүүдийн аюулгүй байдал, хүчирхийллээс хамгаалах шалгуур үзүүлэлтийн хүрээнд, 2 дэд төвийн 6 хорооны Хамтарсан багийг чадваржуулах 2 удаагийн цуврал сургалтыг зохион байгууллаа. Нийт 33 хамтарсан багийн гишүүд хүчирхийллийн кэйсд хэрхэн хариу үйлдэл үзүүлэх талаар онол практикын сургалтанд хамрагдаж, хамтарсан багт тулгамддаг асуудлуудаа эргэн дүгнэж, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөө дахин шинэчиллээ.



### Иргэдийн санал, гомдол түүнийн шийдвэрлэлтийн байдал

2020 онд Дамбадаржаа дэд төвийн бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор нийт 206 өргөдөл гомдол ирсэн байгаагаас газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой 12, газраа чөлөөлхөөс татгалзсан 4, газрын үнэлгээ нөхөн олговортой холбоотой 179, түр суурьших байранд байрлах 3, дулаан цэвэр бохирын шугамд холбогдох 2, инженерийн байгууламжийн барилгын ажлын талаар 3, бүтнээр хамрагдах хүсэлтэй 4, талархал 2 өргөдөл, гомдол ирсэн байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа нь 5 – 30 хоног байна. Нийт 105 өргөдлийг иргэний талд шийдвэрлэсэн бол 101 өргөдөлд шийдвэрлэх боломжгүй хариу өгсөн байна. Нийт өргөдөл гомдлын 98%-ыг шийдвэрлээд байна.

### САНХҮҮЖИЛТЫН ЯВЦ

Хөтөлбөрийн 2-р үе шатны санхүүжилт 2020 оны 12 сарын 31-ны байдлаар АХБ-ны МОН-3525 (COL) зээлийн эх үүсвэрийн 29.24 сая ам.доллараас 7.84 сая ам.долларыг дэд төвүүдэд байригдаж буй нийгмийн барилга байгууламжийн барилга угсралтын ажилд, МОН-3526 (OCR) зээлийн эх үүсвэрийн 37.11 сая ам.доллараас 6.58 сая ам.долларыг дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажилд, ЕХОБ-ны FI'83873 зээлийн эх үүсвэрийн 19.64 сая ам.доллараас 1.35 сая ам.долларыг усан сан, цэвэр бохир усны шугам сүлжээний ажилдад зарцуулсан байна. Нийт санхүүгийн зарцуулалт 13.02%-тай байна.

(сая ам.доллар)

Эх үүсвэр	Санхүүжилт	Зарцуулалт	%
АХБ-ны санхүүжилт			
МОН-3525 (COL)	29.24	7.84	26.82%
МОН-3526 (OCR)	37.11	6.58	17.73%
<b>Дэд дүн</b>	<b>66.35</b>	<b>14.42</b>	<b>21.74%</b>
НЗДТГ-ын төсөв	35.15	0	0%
ЕХОБ-ны санхүүжилт FI'83.873	19.64	1.35	6.87%
<b>Нийт</b>	<b>121.14</b>	<b>15.77</b>	<b>13.02%</b>

2020 онд батлагдсан төсвийн гүйцэтгэлийг дараах хүснэгтэд үзүүлэв.

(төгрөг)

Эх үүсвэр	2020 оны төсөв	Гүйцэтгэл	%
АХБ-ны санхүүжилт			
МОН-3525 (COL)	7,749,900,000.00	4,117,688,788.89	53.13%
МОН-3526 (OCR)	10,120,314,500.00	6,345,267,684.51	62.70%
<b>Дэд дүн</b>	<b>17,870,214,500.00</b>	<b>10,462,956,473.40</b>	<b>58.55%</b>
НЗДТГ-ын төсөв	-	-	-%
ЕХОБ-ны санхүүжилт FI'83.873	6,770,000,000.00	-	0.00%

<b>Нийт</b>	<b>24,640,214,500.00</b>	<b>10,462,956,473.40</b>	<b>42.46%</b>
-------------	--------------------------	--------------------------	---------------

### ХӨТӨЛБӨРИЙН ГУРАВ ДУГААР ҮЕ ШАТ – ТОЛГОЙТ, ШАРХАД ДЭД ТӨВ


#### Хөтөлбөрийн бэлтгэл ажлууд

Хөтөлбөрийн III үе шатны байршлуудыг “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан Техник эдийн засгийг үнэлгээ (ТЭЗҮ)-г зүүн бүсийн Шархад, баруун бүсийн гэр хороолол болох Толгойт дэд төвүүд дээр хийж гүйцэтгэн Төслийн Удирдах хорооны 2019 оны 11-р сарын 11-ний өдрийн хурлаар дээрх байршлуудыг хэлэлцүүлэн батлуулсан.

Зээлийн хөрөнгийн үлдэгдэл ба газарзүйн өгөгдөл, инженерийн шугам сүлжээтэй холбогдох одоогийн нөхцөл байдал, газар ашиглалтын байдал болон Нийслэлээс баримталж буй хөрөнгө оруулалтын чиглэлтэй уялдуулан эхний ээлжийн хөрөнгө оруулалтын талбарыг сонгосон болно.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 7 сарын 31-ны 125 тоот тогтоолоор дэд төвүүдийн байршил талбайн хэмжээг дараах байдлаар эцэслэн тогтоосон. Үүнд:

- Сонгинохайрхан дүүргийн 1,2,3,34,35 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх “Толгойт дэд дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, 736,9 га талбайд”
- Баянзүрх дүүргийн 8,9,10,17,19,24 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх “Шархад дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, 507 га талбайд”



Хөтөлбөрийн 3-үе шатны ТЭЗҮ-г боловсруулах явцад АХБ-ны хяналтын баг нийт 6 удаа Улаанбаатар хотод хүрэлцэн ирж ТХН болон зөвлөх багуудтай хамтран ажилласан ба дэд төвүүдийн хилийн цэс, хөрөнгө оруулалтын жагсаалтыг тусгасан санамж бичгүүдийг боловсруулан АХБ болон МУ-ын холбогдох төсөл хэрэгжүүлэгч хамтран ажиллагч байгууллагууд гарын үсэг зуран баталгаажуулсан байна.

ТЭЗҮ-г боловсруулах ажил 2019 оны 3-р сараас эхлэн хийгдэж сүүлийн тайланг 12-р сард АХБ-д холбогдох бичиг баримтуудын хамт хүргүүлэн хянуулж гэрээний хэлэлцээрийн бэлтгэл ажил эхэлсэн. АХБ-тай хамтарсан төлөвлөгөөний дагуу гэрээний хэлэлцээр 3-р сард МУ-д хийгдэхээр төлөвлөгдсөн байсан боловч Ковид-19 цар тахал гарсантай холбогдон хойшлогдож 2020 оны 5-р сарын 13-14-ний өдрүүдэд хэлэлцээр цахим хэлбэрээр явагдаж талууд гэрээний нөхцөлүүд дээр санал нийлж 12-р сард албан ёсоор гэрээнд гарын үсэг зурахаар тохиролцов.

Уг санхүүжилтийн хүрээнд Шархад, Толгойт дэд төвүүд дээр зам болон шугам сүлжээний ажил хийгдэхээс гадна хүүхдийн цэцэрлэг, спорт цогцолбор, олон нийтийн хөгжлийн төв болон сургалтын төв зэрэг нийгмийн барилга байгууламжууд баригдахаар төлөвлөгдсөн байна. Хөтөлбөрийн III үе шатыг яаралтай эхлүүлэн цаг хугацаанд нь дуусган хүлээлгэн өгөх зорилгоор нийгмийн барилга байгууламжийг өмнөх үе шатуудад хэрэгжүүлсэн нэг маягийн зурагаар хийх бөгөөд дэд бүтцийн нарийвчилсан зураг төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг эхлүүлэн явуулж байна.

УХГХХХОД Хөтөлбөрийн 3 үе шат нь байгаль орчны нөлөөллийн хувьд В категорийн төсөл гэж үнэлэгдсэн бөгөөд АХБ-ны хамгааллын бодлогын (ADB SPS 2009) дагуу 3 үе шатны Байгаль орчны



Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

суурь үнэлгээ ба БОМТ-г төслийн менежментийн зөвлөх байгууллага (ICT Engineering) боловсруулж, 2020 оны 2-р сард АХБ-аар батлуулсан.

Хөтөлбөрийн 3 үе шатны Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд Tranche 3 үе шатанд хамрагдах Толгойт, Шархад дэд төвүүд дээр БОАЖЯ-наас Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулан авсны үндсэн дээр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгэж, 2020 оны 6-р сард БОАЖЯ-аар батлуулсан.

Хөтөлбөрийн 3 үе шатны зээлийн хэлэлцээрийг 2020 оны 12 сарын 30-нд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж АХБ-нд хүргүүлсэн.

*Төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө /сая ам.доллараар/*

Эх үүсвэр	Санхүүжилт	Эзлэх хувь
АХБ-ны санхүүжилт		
МОН-3946 (COL)	18.60	16.29
МОН-3947 (OCR)	25.05	21.93
<b>Дэд дүн</b>	<b>43.65</b>	<b>38.22</b>
НЗДТГ-ын төсөв	51.90	45.45
ЕХОБ-ны санхүүжилт FГ'83873	18.65	16.33
<b>Нийт</b>	<b>114.20</b>	<b>100</b>

№	Үндсэн үйл ажиллагаа	Төлөвлөсөн
<b>А. Суурь зардал</b>		<b>94.40</b>
<i>I</i>	<i>Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх</i>	<i>77.06</i>
1.1	Автозам сайжруулах	50.92
1.2	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, үйлчилгээг сайжруулах	15.34
1.4	Дулааны шугам сүлжээ, үйлчилгээг сайжруулах	10.80
<i>II</i>	<i>Эдийн засгийн болон нийгмийн байгууламжийг нэмэгдүүлэх</i>	<i>14.05</i>
<i>III</i>	<i>Байгууллагыг чадавхижуулах</i>	<i>3.29</i>
<b>Б. Магадлашгүй ажил</b>		<b>16.62</b>
<b>В. Хэрэгжүүлэх үеийн санхүүгийн хураамж</b>		<b>3.18</b>
<b>Нийт дүн</b>		<b>114.20</b>

Хөтөлбөрийн 3-р Үе шатыг дараах бүрэлдэхүүн хэсгүүдээр хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх
2. Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд
3. Төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх

### ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТЫН ЯВЦ

Хөтөлбөрийн санхүүжилтийг хийгдэх ажлуудын ангилалаар хөтөлбөрийн үе шат бүрээр дараах хөрөнгийг зарцуулахаар төлөвлөөд байна

*(сая ам.доллар)*

Эх үүсвэр	Хөтөлбөр	I үе шат	II үе шат	III үе шат
АХБ-ны санхүүжилт				
(COL)	70.34	22.5	29.24	18.6
(OCR)	89.66	27.5	37.11	25.05
МОН-0380	3.7	3.7		



Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

Дэд дүн	<b>163.7</b>	<b>53.7</b>	<b>66.35</b>	<b>43.65</b>
НЗДТГ-ын төсөв	120.2	33.15	35.15	51.9
ЕХОБ-ны санхүүжилт	60.3	22.01	19.64	18.65
<b>Нийт</b>	<b>344.2</b>	<b>108.86</b>	<b>121.14</b>	<b>114.2</b>

(сая ам.доллар)

№	Үндсэн үйл ажиллагаа	Хөтөлбөр	I үе шат	II үе шат	III үе шат
<b>А. Суурь зардал</b>		<b>295.33</b>	<b>97.47</b>	<b>103.46</b>	<b>94.40</b>
<b>I</b>	<i>Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх</i>	<b>242.16</b>	<b>84.77</b>	<b>80.33</b>	<b>77.06</b>
1.1	Автозам сайжруулах	110.54	28.93	30.69	50.92
1.2	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, үйлчилгээг сайжруулах	57.78	25.70	16.74	15.34
1.3	Дулааны шугам сүлжээ, үйлчилгээг сайжруулах	73.84	30.14	32.90	10.80
<b>II</b>	<i>Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үр ашгийг нэмэгдүүлэх</i>	<b>3.70</b>	<b>3.70</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>III</b>	<i>Эдийн засгийн болон нийгмийн байгууламжийг нэмэгдүүлэх</i>	<b>37.89</b>	<b>5.00</b>	<b>18.84</b>	<b>14.05</b>
<b>IV</b>	<i>Байгууллагыг чадавхижуулах</i>	<b>11.58</b>	<b>4.00</b>	<b>4.29</b>	<b>3.29</b>
<b>Б. Магадлашгүй ажил</b>		<b>35.07</b>	<b>7.39</b>	<b>11.06</b>	<b>16.62</b>
<b>В. Хэрэгжүүлэх үеийн санхүүгийн хураамж</b>		<b>13.80</b>	<b>4.00</b>	<b>6.62</b>	<b>3.18</b>
<b>Нийт дүн</b>		<b>344.20</b>	<b>108.86</b>	<b>121.14</b>	<b>114.20</b>

Нийт хөтөлбөрийн санхүүжилтийг дараах хүснэгтээс харна уу

Эх үүсвэр	Хөтөлбөр	Зарцуулалт	%
АХБ-ны санхүүжилт			
(COL)	70.34	24.76	35.20%
(OCR)	89.66	27.21	30.35%
МОН-0380	3.7	3.69	99.73%
<b>Дэд дүн</b>	<b>163.7</b>	<b>51.97</b>	<b>31.75%</b>
НЗДТГ-ын төсөв	120.2	42.58	35.42%
ЕХОБ-ны санхүүжилт	60.3	18.67	30.96%
<b>Нийт</b>	<b>344.2</b>	<b>113.22</b>	<b>32.89%</b>

Хөтөлбөрийн хэрэгжилт 38.15% байхад хөтөлбөрийн зарцуулалт 32.89% байна.

**ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛУУД, СУРГАМЖ**

Төслийн хэрэгжилтэд нөлөөлж буй дараах асуудлууд байна. Үүнд:

1. Халдварт өвчний эрсдэлтэй үеийн арга хэмжээ:



- Дэлхий нийтэд дэгдээд буй коронавирусийн халдвар (COVID-19) тархалтаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийн хамгаалах талаар Засгийн газрын 64 дүгээр тогтоол, Улсын Онцгой комисс, Нийслэлийн Онцгой комисс болон Нийслэлийн Засаг даргын захирамж, бусад тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 2020 оны 07 дугаар сарын 15-нийг дуустал олон нийтийг хамарсан арга хэмжээ, хурал, уулзалт зохион байгуулах боломжгүйгээс үүдэн төлөвлөсөн ажлууд удаашраад байна. Үүнд: Төслийн газар чөлөөлөлтийн асуудлаар иргэдтэй зөвшилцөх уулзалтууд хойшлох, гадаадаас авах бараа материал, холбогдох материалын үйлдвэрлэл зогссоноос шалтгаалан нийт 14 гэрээний хүрээнд барилга угсралтын ажил төлөвлөгдсөн хугацаандаа хийгдэхгүй байх, тодорхой хугацаанд саатах, олон улсын зөвлөх мэргэжилтэн, удирдлагууд Монгол улсад зорчин ирэх боломжгүй болсон зэргээс шалтгаалж барилга угсралтын ажлууд тодорхой хугацаагаар саатах эрсдэлтэй хэвээр байна.
- Мөн Монгол улсын Засгийн газрын 2020 оны 11 сарын 11-ны өдрийн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоолын дагуу бүх барилгын ажил болон олон нийтийн үйл ажиллагааг бүрэн зогсоосон нь барилгын ажлуудын хэрэгжилтийг удаашруулаад байна.
- Дэлхий нийтийг хамарсан короновируст халдвар /Ковид-19/-ын цар тахалаас хамааран улсын эдийн засагт хүндрэлтэй байгаатай холбоотойгоор нийслэлийн 2020 оны төсвийн орлого тасарсан нь Хөтөлбөрийн санхүүжилтийг цаг тухайд нь олгох боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж

## 2. Хөтөлбөрийн II үе шатны хувьд тулгарсан цаашид анхаарах асуудлууд:

- Дулааны эх үүсвэрийн хувьд Дэнжийн мянга дэд төвийг төвлөрсөн дулаан хангамжид холбох техникийн шийдлийн судалгаа тооцоог НЗД-ын 2019 оны А/1317 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хийн дуусгаж 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн НЗД-ын Зөвлөлийн 07 дугаар хуралдаанаар танилцуулсан. Тус хурлаар ажлын хэсгийн гаргасан техникийн шийдлийн дагуу Дэнжийн мянга дэд төвийг төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох Оргил ачааллын горимд ажиллах дулааны эх үүсвэрийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулж, ЭХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна. Уг шийдвэрийн дагуу Төсөл хэрэгжүүлэх нэгжээс Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах даалгаврыг боловсруулан батлуулахаар Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар, ЭХЯ-д хандаад байна. Төслийн инженерийн зураг төсөл хяналтын зөвлөх компани ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлээд байна.
- Дамбадаржаа дэд төвийн дулааны эх үүсвэрийн Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн ба ЭХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж зөвшөөрөл авсан бөгөөд ажлын зураг төсөл хийгдэж байна.
- Цахилгааны эх үүсвэрийн хувьд 2019 онд төсөл хэрэгжүүлэх нэгжээс Диспетчерийн үндэсний төвд Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төвүүдийн цахилгааны эх үүсвэрийн горимын тооцоо хийлгэх хүсэлт гаргасан боловч тус төвөөс горимын тооцоог 2020 оны 4 дүгээр сарын 3-ны өдрөөс өмнө хийн ирүүлэх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн байна. Тухайн горимын тооцооны үр дүнгээс цахилгааны эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэх чиглэл гарна. Уг асуудлыг 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн НЗД-ын Зөвлөлийн хуралдаанд танилцуулж хуралдаанаас Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газарт дэд төвүүдийн цахилгааны эх үүсвэрийг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх үүргийг өгсөн байна. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 769 тоот албан бичгээр холбогдох тайлбар, тодруулгыг ЭХЯ-д дахин хүргүүлсэн. 2020 оны 07 дугаар сарын хурлаар дахин хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна.
- Дамбадаржаа дэд төвийн барилгажилтын төсөл, авто зам, дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуурга болон инженерийн бэлтгэл арга хэмжээний зургуудыг бэлтгэж боловсруулж дуусан зөвшилцөх ажил хийгдээд байна. Гэвч Дамбадаржаа дэд төвийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг хангахаар ТЭЗҮ дээр тусгасан байсан Сэлбэ 110/35/10кВ станц нь ашиглалтын шаардлага хангахгүй, зөөж шинээр барих шаардлагатай болсноос тус дэд төвийн цахилгааны техникийн нөхцөл олгогдоогүй байна. Техникийн нөхцөл гараагүйгээс бусад инженерийн шугам сүлжээний зураг төслийг зөвшилцөх батлуулах ажил гацаанд ороод байна. Уг техникийн нөхцөлийг авах ажил болон



Дамбадаржаа дэд төвийн ойролцоо цахилгааны шинэ эх үүсвэр барих ажлыг Эрчим хүчний яамтай бодлогын түвшинд хэлэлцэж шийдвэрлэх үал ажиллагаанд хугацаа их зарцуулж зураг төслийн ажлуудыг удаашруулаад байна.

Зорилтот дэд төвүүдийн цахилгаан, дулааны эх үүсвэрийн асуудал болон газрын асуудлаас шалтгаалан төслийн хүрээнд хийхээр төлөвлөж буй нийгмийн барилга байгууламжуудын гадна шугам сүлжээний нарийвчилсан зураг төслийг боловсруулж эцэслэхэд шаардлагатай холбогдох техникийн нөхцлүүдийг авахад хүндрэлтэй байгаагаас төслийн худалдан авах ажиллагааг эхлүүлэх боломжгүй нөхцөл үүсээд байна.

## **ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ДАГАЖ МӨРДӨЖ БУЙ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД**

Төслийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн баримт бичгүүдэд дараах баримт бичгүүд багтана. Үүнд:

1. Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр (СЕХ) /2014 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Монгол УИХ-аар соёрхон баталсан/
2. СЕХ-ийн дагалдах баримт бичгүүд:
  - a. Үе шат 1-ийн санхүүжилтэнд хамаарах МУ-ын Засгийн Газар ба АХБ хооронд байгуулсан зээлийн гэрээ:
    - i. Төслийн гэрээ МОН-3098, МОН-3099, МОН-0380 /2013 оны 6 дугаар сарын 30/
    - ii. Тусгай сангийн зээлийн гэрээ МОН-3099 /2013 оны 6 дугаар сарын 30/
    - iii. Ердийн эх үүсвэртэй санхүүжилтийн зээлийн гэрээ МОН-3098 /2013 оны 6 дугаар сарын 30/
    - iv. Буцалтгүй тусламжийн санхүүжилтийн гэрээ МОН-0380 /2013 оны 6 дугаар сарын 30/
  - b. Үе шат 2-ын санхүүжилтэнд хамаарах МУ-ын Засгийн Газар ба АХБ хооронд байгуулсан зээлийн гэрээ:
    - i. Төслийн гэрээ МОН-3525, МОН-3526(COL) /2017 оны 12 дугаар сарын 06/
    - ii. Концессийн ердийн эх үүсвэртэй санхүүжилтийн зээлийн гэрээ МОН-3526(COL) /2017 оны 12 дугаар сарын 06/
    - iii. Ердийн эх үүсвэртэй санхүүжилтийн зээлийн гэрээ МОН-3525/2017 оны 12 дугаар сарын 06/
  - c. Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн дагуу МУ ба Европын Хөрөнгө Оруулалтын Банктай байгуулсан зээлийн гэрээ F183.097, F183.873 /2013 оны 6 дугаар сарын 30, Төслийн үе шат 1,2-т хамаарна/
  - d. Олон шатлалт санхүүжилтийн зээлийн шугам (ОШСЗШ)-ын удирдлагын баримт бичиг /АХБ-ны Удирдах Зөвлөлөөс 2013 оны 08 дугаар сард баталсан, Төсөл 2-т холбогдуулан 2017 оны 3 дугаар сард шинэчлэн баталсан/
3. МУ-ын Сангийн сайдын 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”

## **ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**

Хөтөлбөрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үүднээс дэд төвүүдийн иргэдэд төслийн үйл ажиллагааг танилцуулах, явцын мэдээлэл өгөх зэргээр олон удаагийн зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулж улирал тутмын сонинг тараан ажилласан.

Төслийн үйл ажиллагаан тайланг улирал бүрээр, барилгын ажлын явцын мэдээллийг сар бүр бэлтгэн төслийн оролцогч талуудад цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргэж ажиллаж байна.

Хөтөлбөрийн цахим хуудсанд [www.ub-subcenter.mn](http://www.ub-subcenter.mn) байрлах мэдээллийг дараах байдлар төрөлжүүлсэн.

1. Үйл ажиллагааны ил тод байдал

Хөтөлбөрийн үйл ажиллагааны явцын тайлан мэдээг байршуулдаг.

2. Хүний нөөцийн ил тод байдал



## Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

Төслийн нэгжийн хүний нөөцийн холбогдолтой мэдээллүүд буюу нээлттэй ажлын байрны зарууд, анкетын загвар, байгууллагын дотоод журам, ёс зүйн дүрэм, ажилд сонгон шалгаруулах журам зэрэг мэдээллийг байршуулдаг.

### 3. Албан хаагчдын утасны жагсаалт

Төслийн нэгжийн ажилчдын холбоо барих мэдээлэл, өргөдөл гомдол хариуцсан албан хаагчийн холбоо барих мэдээлэл зэргийг байршуулсан.

### 4. Шилэн данс

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011), Шилэн дансны тухай хууль (2014)-ийн дагуу төслийн худалдан авах ажиллагааны болон санхүүгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудас [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) холбогдох мэргэжилтнүүд тодорхой хугацаанд нь байршуулж ажиллаж байна.

Хөтөлбөрийн цахим хуудсыг ажлуулж мэдээлийг тогтмол шинэчлэн ажиллаж байгаа бөгөөд нийгмийн сүлжээгээр төслийн үйл ажиллагааны явц, онцлох мэдээ мэдээллийг цаг алдалгүй нийтэлж ажиллаж байна. ([FB page: Гэр Хорооллыг Хөгжүүлэх Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Хөтөлбөр Төсөл](#))



## ХАВСРАЛТ 1. ГЭРЭЭ БАЙГУУЛАЛТЫН ЯВЦ

## Хөтөлбөрийн 1-үе шатны хүрээнд байгуулсан гэрээ болон түүний хэрэгжилтийн явц

№	Багцын дугаар	Ажлын нэр	Гэрээ байгуулсан дүн	Гэрээний хугацаа		Бодит явц
				Эхлэх	Дуусах	
<b>Бүрэлдэхүүн 1</b>			<b>64,805,524.62</b>			
	АХБ-ны зээл		<b>43,771,853.41</b>			
1	SHF06	Сэлбэ Дулааны станц, 26МВт, 1ш	6,710,530.55	7/17/2017	11/24/2020	78.03%
2	SRDH14	Сэлбэ Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - үе шат 2	5,870,817.04	9/11/2017	6/15/2021	71.11%
3	SRDH11	Сэлбэ Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - Үе шат 1	7,169,244.10	2/23/2018	6/30/2021	86.54%
4	<b>BHF06</b>	<b>Дулааны шугамын өргөтгөл шинэчлэл</b>	<b>3,681,207.64</b>	<b>9/3/2018</b>	<b>12/15/2019</b>	<b>100.0%</b>
5	BRDH14	Баянхошуу Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - Үе шат 2	8,218,290.70	10/29/2018	6/30/2021	75.37%
6	SBR08	Сэлбэ дэд төвийн Гүүр	1,051,071.02	10/15/2018	6/30/2020	97.60%
7	BRDH11	Баянхошуу Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - Үе шат 1	6,585,963.33	11/16/2018	6/30/2021	74.72%
8	BEC13	Баянхошуу Цахилгаан, холбооны шугам сүлжээ	2,151,473.52	11/16/2018	12/15/2020	88.98%
9	SEC13	Сэлбэ Цахилгаан, холбооны шугам сүлжээ	2,333,255.51	12/18/2018	12/15/2020	92.00%
	ЕХОБ-ны санхүүжилт		<b>21,033,671.21</b>			
10	SCM	Сэлбэ Бохирын гол шугам (EIB)	<b>1,040,806.74</b>	<b>4/14/2016</b>	<b>8/1/2017</b>	<b>100.0%</b>
11	BCM1	Баянхошуу 1	<b>1,279,862.99</b>	<b>5/15/2016</b>	<b>11/30/2016</b>	<b>100.0%</b>
12	BCM2	Баянхошуу 2	<b>932,078.01</b>	<b>8/29/2016</b>	<b>11/30/2016</b>	<b>100.0%</b>
13	WWTPR01	Төв цэвэрлэх шинэчлэл	<b>2,281,585.32</b>	<b>9/14/2017</b>	<b>8/1/2019</b>	<b>100.0%</b>
14	WSNR17C	Орос 14-өөс төвийн шугам	<b>219,314.27</b>	<b>10/11/2017</b>	<b>8/1/2019</b>	<b>100.0%</b>
15	BSDF07 Lot 1	Үерийн хамгаалал, далан суваг (EIB)	<b>457,178.95</b>	<b>11/21/2017</b>	<b>5/6/2018</b>	<b>100.0%</b>
16	BSDF07 Lot 2	Үерийн хамгаалал, далан суваг (EIB)	<b>788,688.27</b>	<b>11/21/2017</b>	<b>9/30/2020</b>	<b>100.0%</b>
17	BSPE	Яндан хоолой нийлүүлэх	<b>1,483,848.70</b>	<b>11/12/2017</b>	<b>5/6/2018</b>	<b>100.0%</b>
18	BSWR10 Lot 2	Усан сан (EIB)	<b>1,139,163.25</b>	<b>12/5/2017</b>	<b>6/30/2020</b>	<b>100.0%</b>
19	BSWR10 Lot 1	Баянхошуу Усан сан	1,862,831.02	12/5/2017	6/30/2020	92.75%
20	WSNR17A	Улаанбаатар хотын зүүн хойд бүсийн усан сангаас Тасганы усан сан хүртэлх ,	2,809,483.17	1/23/2018	12/31/2020	32.66%
21	WSNR17B	Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх7054м	2,722,141.11	4/11/2018	12/31/2020	57.83%



## Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

22	WSC16A	Салбар шугамын холболт	1,846,899.00	7/24/2019	5/24/2020	86.75%
23	BPDF07B	Баянхошуу Үерийн хамгаалалын суваг, шинэ	2,169,790.41	8/20/2019	6/20/2021	75.8%
<b>Бүрэлдэхүүн 2</b>			<b>7,987,324.22</b>			
1	BSF Lot 1	БАГЦ 1 - 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга	1,064,577.84	9/17/2017	9/19/2018	100.0%
2	BSF Lot 2	БАГЦ 2 - МСҮТ, бизнес инкубаторын барилга	1,299,502.98	9/22/2017	9/22/2018	100.0%
3	BFKA	Баянхошуу цэцэрлэгийн тавилга, тоног төхөөрөмж	60,421.00	10/19/2018	11/16/2018	100.0%
4	SSF Lot 1	БАГЦ 1 - 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга	1,053,871.33	1/17/2019	5/31/2020	100.0%
5	SSF Lot 2	БАГЦ 2 - МСҮТ, бизнес инкубаторын барилга	855,238.33	1/17/2019	5/31/2020	100.0%
6	BEF	Баянхошуу бизнес инкубаторын тавилга, тоног төхөөрөмж	71,977.00	3/26/2019	4/16/2019	100.0%
7	BSLS09 Lot 2	Сэлбэ Төхижилт, ландшафт, 3.01га	1,380,356.23	3/25/2019	6/17/2020	85.90%
8	BSLS09 Lot 1	Баянхошуу Төхижилт, ландшафт, 4.65 га	1,127,264.57	8/2/2019	9/2/2020	88.30%
9	SEF	Сэлбэ бизнес инкубаторын тавилга, тоног төхөөрөмж	103,426.00	6/26/2020	7/20/2020	100.0%
10	SFKA	Сэлбэ цэцэрлэгийн тавилга, тоног төхөөрөмж	50,933.00	7/23/2020	8/23/2020	100.0%
11	PP01-SW	Баянхошуу дэд төвд Орлогод нийцсэн орон сууцны туршилт, 20 айлын орон сууц, 1ш	846,555.94	8/21/2020	7/21/2021	35.63%
12	TFBA	Чөлөөлсөн талбайг хашаалах НОСК, 1500м	73,200.00			0.00%
<b>Бүрэлдэхүүн 3</b>			<b>3,698,952.00</b>			
1	WWOI	УСУГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ (Буцалтгүй тусламж)	3,698,952.00	10/13/2016	9/30/2018	100.00%
<b>Бүрэлдэхүүн 4</b>			<b>10,149,641.81</b>			
АХБ-ны зээл			<b>9,766,414.02</b>			
1	ICS1-3	Олон улсын зөвлөхүүд	165,796.11	1/1/2015	1/1/2016	100.00%
2	NCS4-9	Дотоодын зөвлөхүүд		1/1/2015	1/1/2016	100.00%
3	CS/CSDD	Инженерийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	3,084,029.00	5/29/2015	7/2/2018	100.00%
4	CS2/CSPM	Төслийн удирдалагад дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ	1,274,807.67	6/5/2015	6/5/2018	100.00%
5	CS3/CSCE	Олон нийтийн оролцоог хангах ЖДҮ-г хөгжүүлэх зөвлөх үйлчилгээ	749,603.00	6/25/2015	6/30/2018	100.00%
6	CS4/CSSD	Хотын төлөвлөлт болон дэд төвийн төлөвлөтийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ	780,078.48	8/28/2015	6/30/2018	100.00%



## Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

7	CSBHF06A	Дулааны шугам сүлжээний өргөтгөлийн зураг төсөл боловсруулах	62,129.78	5/18/2018	11/19/2018	100.00%
8	CS CSDS	Сэлбэ дулааны станцын ТЭЗҮ, Баянхошуу Сэлбэ дэд төвүүдийн инженерийн гадна холбоосны зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	196,072.96	10/19/2018	11/19/2019	100.00%
9	PP01 DD	Орлогд нийцсэн орон сууцны зураг төсөл боловсруулах	69,520.00	1/29/2019	9/15/2019	100.00%
10	CSDA	Зохиогчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ	899,997.50	6/25/2019	3/25/2021	100.00%
11	ES-COL OCR	Захиалагчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ	846,954.76	6/27/2019	12/31/2020	100.00%
12	CSO1	Хотын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх зөвлөх үйлчилгээ	438,508.00	12/20/2019	2/12/2021	38.00%
13	PMO staff		1,198,916.76			100.00%
	ЕХОБ-ны санхүүжилт		<b>383,227.79</b>			
14	DS-NHOG	Зураг төслийн ажилд хяналт тавих зөвлөх үйлчилгээ	166,613.58	1/21/2019	12/30/2020	100.00%
15	ES-NHOG	Барилгын ажидл хяналт тавих зөвлөх үйлчилгээ	216,614.21	5/31/2018	12/31/2020	100.00%
<b>Нийт</b>			<b>86,641,442.65</b>			


**ХАВСРАЛТ 2. УЛСЫН КОМИССТ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН БАРИЛГЫН АЖЛУУД**

Бүрэлдэхүүн 1. Авто зам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх хүрээнд бүрэн гүйцэтгэгдэн улсын комисст хүлээлгэн өгсөн барилгын ажлууд

2016 ОН

**1. Баянхошууны 1-р хэсгийн өөрийн урсгалтай ариутгах татуургын барилгын ажил (ВСМ1)**


<b>Хүчин чадал / үзүүлэлт:</b>	416 м DN450&500-ийн зөөлөн ширмэн 3 ш хоолойтой өөрийн урсгалтай ариутгах татуургын шугам
<b>Гүйцэтгэгч:</b>	Бумбод ХХК, ДҮКВ ХХК түншлэл
<b>Улсын комисст хүлээлгэн өгсөн хугацаа, актын дугаар:</b>	2016 оны 12 сарын 21 2016/625



2017 ОН

**2. Баянхошууны 2-р хэсгийн өөрийн урсгалтай ариутгах татуургын шугамын барилгын ажил (ВСМ2)**

<b>Хүчин чадал / үзүүлэлт:</b>	2250м DN600 өөлөн ширмэн хоолойтой өөрийн урсгалтай ариутгах татуургын шугам
<b>Гүйцэтгэгч:</b>	Бумбод ХХК, ДҮКВ ХХК түншлэл
<b>Улсын комисст хүлээлгэн өгсөн хугацаа, актын дугаар:</b>	2017 оны 10 сарын 24 2017/283



### 3. Сэлбэ дэд төвийн бохирын шугам сүлжээний угсралтын ажил (SCM)

<b>Хүчин чадал/ үзүүлэлт:</b>	2183метр DN400-ийн зөөлөн ширмэн хоолойтой өөрийн урсгалтай ариутгах татуургын шугам
<b>Гүйцэтгэгч:</b>	Хүрд ХК
<b>Улсын комисст хүлээлгэн өгсөн хугацаа, актын дугаар:</b>	2017 оны 12 сарын 28 2017/605



2018 ОН

### 4. Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажил (BSDF07 lot 1)


<b>Хүчин чадал / үзүүлэлт:</b>	2.4 км урттай үерийн хамгаалалтын суваг;
<b>Гүйцэтгэгч:</b>	“Хангилцаг” ХХК
<b>Улсын комисст хүлээлгэн өгсөн хугацаа:</b>	2018 оны 11 сарын 19 2018/617



2019 ОН

**5. Улаанбаатар хотын Орос 14-р сургууль орчмын барилга байгууламжийн бохирын татуургын гол цуглуулах шугамын барилга угсралтын ажил (WSNR17C)**

<b>Хүчин чадал / үзүүлэлт:</b>	φ400мм-ийн зөөлөн ширмэн ариутгах татуургын шугам - 543м
<b>Гүйцэтгэгч:</b>	“Модерн Хас” ХХК, “Монгол Менежмент Төв” ХХК
<b>Улсын комисст хүлээлгэн өгсөн хугацаа:</b>	2019 оны 7 сарын 16 2019/246




**6. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилга болон аэротанкийн бетон хийцийн шинэчлэлтийн ажил (WWTPR01)**

<b>Хүчин чадал / үзүүлэлт:</b>	Дугуй резервуарын барилга болон Аэротанкийн бетон хийцийг засч шинэчлэх; 10.000 диффузор, агаарын шугам селектор суурилуулах;
<b>Гүйцэтгэгч:</b>	“Эс Энд Эй Трейд” ХХК, “Набсан” ХХК-ийн түншлэл
<b>Улсын комисст хүлээлгэн өгсөн хугацаа:</b>	2019 оны 7 сарын 22 2019/255



**7. Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны 11и магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил (ВНF06)**

<b>Хүчин чадал / үзүүлэлт:</b>	2ф500мм шугамыг 2ф700мм болгон өргөтгөх 1600 м; 2ф400мм шугамыг 2ф600мм болгон өргөтгөх 1600 м;
<b>Гүйцэтгэгч:</b>	“ЧММ” ХХК, “Эс Энд Эй Трейд” ХХК-иудын түншлэл
<b>Улсын комисст хүлээлгэн өгсөн хугацаа, актын дугаар:</b>	2019 оны 9 сарын 18 2019/358



**8. Сэлбэ дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус хангамжийн шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажил (BSWR10, Багц 2)**

<b>Хүчин чадал / үзүүлэлт:</b>	1000м3 хүчин чадалтай усан сан; Доод насос станцын барилга-1, Өргөлтийн насос станцын барилга-1; Ус дамжуулах шугам - 5370м;
<b>Гүйцэтгэгч:</b>	“Санжат” ХХК
<b>Улсын комисст хүлээлгэн өгсөн хугацаа, актын дугаар:</b>	2019 оны 11 сарын 29 2019/701



2020 ОН

**9. Сэлбэ дэд төвд үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралт болон ҮХС-ийн хамгаалалтын хайсны угсралт суурилуулалтын ажил (BSDF07, lot 2)**

<b>Хүчин чадал / үзүүлэлт:</b>	Үерийн хамгаалал, далан суваг – 2423м
<b>Гүйцэтгэгч:</b>	“Экспресс Зам” ХХК
<b>Улсын комисст хүлээлгэн өгсөн хугацаа, актын дугаар</b>	2020 оны 09 сарын 10 БА-030/2020



### ХАВСРАЛТ 3. УЛСЫН КОМИССТ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН БАРИЛГЫН АЖЛУУД

Бүрэлдэхүүн 2. Нийгэм, эдийн засгийн барилга байгууламж хүрээнд бүрэн гүйцэтгэгдэн улсын комисст хүлээлгэн өгсөн барилгын ажлууд  
2018 ОН

#### 1. Баянхошуу дэд төвд барих 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил (BSF05 lot 1)

<b>Хүчин чадал / үзүүлэлт:</b>	2 давхар, 240 хүүхдийн ортой цэцэрлэг, Нийт хэмжээ: 2027.17м <sup>2</sup>
<b>Гүйцэтгэгч:</b>	“Ус Орчин” ХХК
<b>Улсын комисст хүлээлгэн өгсөн хугацаа, актын дугаар:</b>	2018 оны 12 сарын 11 2018/737



#### 2. Баянхошуу дэд төвд барих МСҮТ, бизнес инкубатор төвийн барилга угсралтын ажил (BSF05 lot 2)

<b>Хүчин чадал / үзүүлэлт:</b>	2 давхар, Нийт хэмжээ: 2066м <sup>2</sup>
<b>Гүйцэтгэгч:</b>	“Томо Бьюлдинг” ХХК
<b>Улсын комисст хүлээлгэн өгсөн хугацаа, актын дугаар:</b>	2018 оны 12 сарын 11 2018/737



**2020 ОН**

**3. Сэлбэ дэд төвд барих 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил (SSF05, Багц 1)**

<b>Хүчин чадал / үзүүлэлт:</b>	2 давхар, 240 хүүхдийн ортой цэцэрлэг, Нийт хэмжээ: 2027.17м2
<b>Гүйцэтгэгч:</b>	“Цаст Констракшн” ХХК
<b>Улсын комисст хүлээлгэн өгсөн хугацаа:</b>	2020 оны 8 сарын 27 БА-016/2020



**4. Сэлбэ дэд төвд барих МСҮТ, бизнес инкубатор төвийн барилга угсралтын ажил (SSF05, Багц 2)**

<b>Хүчин чадал / үзүүлэлт:</b>	2 давхар, Нийт хэмжээ: 2066м2
<b>Гүйцэтгэгч:</b>	“Бридж Констракшн” ХХК, “Монхас” ХХК-ийн түншлэл
<b>Улсын комисст хүлээлгэн өгсөн хугацаа:</b>	2020 оны 9 сарын 9 БА-027/2020



## ХАВСРАЛТ 4. УЛСЫН КОМИССТ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН БАРИЛГЫН АЖЛУУД

### Бүрэлдэхүүн 3. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын менежментийг бэхжүүлэх хүрээнд бүрэн гүйцэтгэгдэн улсын комисст хүлээлгэн өгсөн барилгын ажлууд 2018 ОН

#### 1. УСУГ-ын үйл ажиллагааг сайжруулах (WVOI)

<b>Гүйцэтгэгч:</b>	“Комфорт Импекс” ХХК, "Хунан Шиангнү Энвайронментал Протекшн Индустриал" ХХК-иудын түншлэл
<b>Хийж гүйцэтгэсэн ажлууд:</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Төвийн эх үүсвэрийн 6кВ-ын 750кВт-ын хүчин чадал бүхий цахилгаан хөдөлгүүрт Harvest Schneider брэндийн давтамж хувиргагч суурилуулсан.</li> <li>• Үйлдвэр, Мах, Төв болон Гачуурт насос станцуудад насосын давтамж хувиргагч, өргөлтийн насосууд суурилуулж автоматжуулалт, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн</li> <li>• Түгээх байрнуудын сүлжээний удирдлагын болон хэмжих хугдгуудын барилга угсралтын ажлууд хийгдсэн.</li> <li>• Ус хангамжийн шугам сүлжээнд хэмжилтийн 40 хугдгийн хяналтын 30 хугдгийг шинээр барьж, 10 хугдгийг шинэчлэн засварласан.</li> <li>• УСУГ-ын удирдлагын төвд СКАДА систем, усны алдагдлыг илрүүлэх , нэгдсэн удирдлагын програм хангамж суурилуулсан</li> <li>• Төв цэвэрлэх байгууламжид СКАДА програм хангамж болон 39,700м шилэн кабелийн суурилуулалтыг хийж гүйцэтгэсэн.</li> </ul>
<b>Улсын комисст хүлээлгэн өгсөн хугацаа:</b>	2018 оны 11 сарын 28 2018/605



**ХАВСРАЛТ 5. ГЭРЭЭ БАЙГУУЛАЛТЫН ЯВЦ****Хөтөлбөрийн 1-үе шатны хүрээнд байгуулсан гэрээ болон түүний хэрэгжилтийн явц**

№	Багцын дугаар	Ажлын нэр	Гэрээ байгуулсан дүн	Гэрээний хугацаа		Бодит явц
				Эхлэх	Дуусах	
<b>Бүрэлдэхүүн 1</b>			<b>19,427,446.34</b>			
	АХБ-ны зээл		<b>12,514,938.00</b>			
1	BHF06B	Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, дулааны даралт өргөх, насус станц, ус дулаан дамжуулах төв, дулааны шинэ шугамын зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралтын ажил	7,061,203	10/12/2018	6/29/2020	94,4%
2	GWD14	Сэлбийн хөрсний ус зайлуулах 2,2 км шугамын ажил	1,261,321	9/30/2019	6/7/2020	100%
3	GWD11	Сэлбийн хөрсний ус зайлуулах 1,3 км шугамын ажил	638,766	9/30/2019	6/7/2020	100%
4	SHS	Нүүлгэн шилжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх 126 айлын түрээсийн орон сууц	3,553,648	11/18/2020	2/17/2022	0%
ЕХОБ-ны санхүүжилт			<b>6,912,508.34</b>			
5	WSC16B		2,006,608.00	5/22/2020	9/2/2021	75,7%
6	HSSC-A		300,000.00	10/1/2020	8/1/2021	43%
7	HSSC-B		669,281.82	10/1/2020	10/1/2021	43,23%
8	USF		3,936,618.52	10/23/2020	10/23/2021	0%
<b>Бүрэлдэхүүн 2</b>			<b>94,096.00</b>			
1	LAE	Газрын албаны тоног төхөөрөмж	94,096.00	3/23/2020	5/11/2020	100%
<b>Бүрэлдэхүүн 3</b>			<b>9,423,255.00</b>			
1	T2-CS01	Инженерийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	5,689,155.00	11/16/2018	6/22/2022	25.32%
2	T2-CS02	Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж чадавх бэхжүүлэх зөвлөх үйлчилгээ	3,734,100.00	1/4/2019	1/4/2022	42.70%
<b>Нийт</b>			<b>28,944,797.34</b>			

**ХАВСРАЛТ 6. УЛСЫН КОМИССТ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН БАРИЛГЫН АЖЛУУД**

**Бүрэлдэхүүн 1. Авто зам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх хүрээнд бүрэн гүйцэтгэгдэн улсын комисст хүлээлгэн өгсөн барилгын ажлууд**

**2020 ОН**

**1. Сэлбэ дэд төвийн хөрсний ус зайлуулах шугам хоолойн барилга угсралтын ажил, 2-р хэсэг (GWD14)**

<b>Хүчин чадал / үзүүлэлт:</b>	Хөрсний ус зайлуулах шугам - 2260м;
<b>Гүйцэтгэгч:</b>	“Вайт Финикс” ХХК, “Хасу Мегаватт” ХХК, “Эвт Трак” ХХК-иудын түншлэл
<b>Улсын комисст хүлээлгэн өгсөн хугацаа:</b>	2020 оны 10 сарын 12 ШС-63/2020



**2. Сэлбэ дэд төвийн хөрсний ус зайлуулах шугам хоолойн барилга угсралтын ажил, 1-р хэсэг (GWD11)**

<b>Хүчин чадал / үзүүлэлт:</b>	Хөрсний ус зайлуулах шугам - 1305м;
<b>Гүйцэтгэгч:</b>	“Набсан” ХХК, “Тэргүүн Инвест” ХХК, “Тэгш Плант” ХХК-иудын түншлэл
<b>Улсын комисст хүлээлгэн өгсөн хугацаа:</b>	2020 оны 10 сарын 30 ШС-89/2020

